**“Чухамжаргалан” ХХК**

# ӨМНӨГОВЬ АЙМАГ, ГУРВАНТЭС СУМЫН НУТАГТ ОРШИХ ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ “ БАРИЛГЫН ЧУЛУУНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АШИГТ МАЛТМАЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:SGMV-00009

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:3614093

**Хянасан:**

БОУАӨЯ-ний ХБОБНУГ-ын мэргэжилтэн: ........................./ /

**Хэрэгжилтийг гаргасан:**

Үйл ажиллагаа хариуцсан захирал ........................./ Г.Гантулга/

Байгаль орчны мэргэжилтэн: ................................/ Д.Болортуяа/

**Гурвантэс сум 2025 озн**

## Гарчиг


- 1.1 Төслийн байршил, мэдээлэл ..... 5
- 1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл: ..... 6
- 1.3 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал ..... 6

***1.3.1. Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө*** ..... 6

***1.3.2. Усан хангамж*** ..... 7

***1.3.3. Цахилгаан хангамж*** ..... 9

- **1.4 Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал** ..... 11
- **1.5 Төслийн үр ашиг** ..... 12
- **1.6 Төслийн техник тоног төхөөрөмж** ..... 13
- 1.7 Ажиллах хүчний тухай мэдээллүүд ..... 14
- **1.8 Уурхайн технологийн дараалал** ..... 14
- **1.9 Тухайн жилийн уурхайн ашиглалтын төлөвлөгөө** ..... 15

**2.1. Уур амьсгал** ..... 16

**2.2. Агаарын чанар** ..... 16

**2.3. Гадаргын ус** ..... 17

**2.4. Газрын доорх ус** ..... 17

**2.5. Хөрсөн бүрхэвч** ..... 18

**2.6. Амьтны аймаг** ..... 19

- 3.1. Төслийн болзошгүй нөлөөлөл ..... 20
- 3.2. **Төслийн гол сөрөг нөлөөлөл** ..... 28

Тоос дарах төхөөрөмж буюу мананжуулагч байрлуулах, орлуулах бууруулах арга хэмжээ авах ..... 36

Ахх цэг сайжруулах ..... 39

Жил бүр ургамлын судалгаа мониторинг явуулах, нөхөн сэргээлт хийхэд тохиромж үр түүх ..... 42

Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт хийж байх ..... 46

Шувууны нислэгийн чиглэл өөрчлөгч /үргээгч/ болон шувууны суулт /үүр/ суурилуулах ..... 47

Газрын нурал, элэгдлээс хамгаалах далан, хашлага хийх ..... 49

Төсөлд өртсөн газар нутагт ургамалжилт, хөрс, амьдрах орчныг сэргээх ажлын хүрээнд төслийн хүрээнд ойр байдаг хөв булгийг түшиглэн урсацыг сайжруулан, ам амьтан услах уст цэг байгуулах ..... 52

Тэрбум мод ажлын хүрээнд ..... 54

Биотехникийн ажлын тайлан ..... 55

5.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай ..... 60

Ажилчдад хабэа-ны ажлын хувцас, малгай, хошуувч, гутал ..... 68

Гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах, галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах ..... 70

Хог хаягдлыг Гурвантэс сумын “Шугшаа-Уул” ОНӨААТҮГ-тай хамтран ажиллах гэрээ хийж, нийлүүлж ажилладаг ..... 74

Хог хаягдлын ангилсан цэгийг засч тохижуулах ..... 76

Аюултай хог хаягдал ..... 77

Цаг хугацаанд бохир зайлуулах гэрээний дагуу зайлуулах ..... 78

Хөдөлмөрийн аюулгүй байдал, байгаль хамгааллын сургалт зохион байгуулах ..... 79

3. Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 51

Хөрсний шинжилгээг гэрээт байгууллагаар шинжлүүлэх, дата үүсгэх:.............................................51

# 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Барилгыш чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах" төсөл нь Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Урт багийн нутагт орших SGMV-00009 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 103.9 га талбайд хэрэгжинэ. Төсөл хэрэгжүүлэгч нь 1111003044 улсын бүртгэлийн дугаартай, 3614093 регистрийн дугаар бүхий Чухамжаргалан ХХК юм.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2015 оны 11 сарын 26-ны өдрийн тушаалаар тус аймгийн Гурвантэс сумын Урт багийн нутагт орших "Хөв" нэртэй, 00024Х дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг "Чухамжаргалан" ХХК-нд олгосон байдаг. Ордын нөөцийг тогтоох зорилгоор эрэл, хайгуулын ажлыг "Хөв" талбайн хойд хэсэгт 2017 оны 8 дугаар сарын 15-наас эхлэн 2017 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэжээ.

Ордын нөөцийг бодитой (В) зэргээр 442.77 мян.м3, боломжтой (С) зэргээр 145.00 мян.м3, нийт (В+С) 587.77 мян.м3 гэж Эрдэс баялаг, мэргэжлийн зөвлөлөөр 2018 онд батлуулжээ (ЭБМЗ-ийн дүгнэлт, дугаар ХХ-12-04).

Энэхүү батлагдсан нөөцөд үндэслэн Өмнөговь аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/1537 дугаар захирамжаар тус аймгийн Гурвантэс сумын Урт багийн Хөв нэртэй газар орших 103.9 гектар талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын 86МУ- 00009 тоот тусгай зөвшөөрлийг Чухамжаргалан ХХК-д олгосон.

Батлагдсан нөөц, тусгай зөвшөөрлийн мэдээлэл, Чухамжаргалан ХХК-ийн Техникийн даалгаварт үндэслэн, техник-эдийн засгийн үндэслэлийг Майндата ХХК боловсруулж, ЭБМЗ- өөр хэлэлцүүлэн 2019 оны 06 сарын 27-ны өдрийн Т/19-11-07 тоот дүгнэлтүүдийг үндэслэн АМГТГ-ын даргын 2019 оны 08 сарын 07-ны өдрийн Т/126 тоот тушаалаар ТЭЗҮ-г батлуулан ажилласан.

Түгээмэл тархацтай ашигт малтал Хөв нэртэй ордод "Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл" 5 жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд жилд 88 мян.м3 дайрга олборлох хүчин чадалтай болно. Ил уурхай нь улирлын чанартай дулааны улирал 7 сарын хугацаанд жилд 220 хоног, хоногт 2 ээлж, ээлжинд 12 цагаар ажиллана. Энэхүү төсөлд 11 албан тушаалд 28 хүн ажиллахаар төлөвлөсөн болно.

Уурхайн ашиглалтын хугацаанд ил уурхайгаас 138.6 мян.м3 хөрс хуулж, 426.8 мян.м3 барилгын чулуу олборлоно. Хөрс хуулалтын коэффициент (Кхх)=0.33 м3/тн

байна. Хөрс хуулалт, олборлолтонд ажиллах экскаваторыг 1.1 м3 утгуурын багтаамжтай экскаватор гүйцэтгэх бөгөөд 15 тн-ийн даацтай Номю загварын автосамосвал тээвэрлэлтийн ажлыг гүицэтгэнэ. Мөн $3м^3$ багтаамжтай ачигч анхдагч дайргыг бутлуурт хийж түүнээс төслийн эцсийн бүтээгдэхүүн гарах бөгөөд ашиглалтын 5 жилийн хугацаанд 418.0мян.м3 дайрга үйлдвэрлэнэ. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчны мэргэжлийн байгууллага болох Тотбат ХХК боловсруулж, БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн дэд зөвлөлөөр 2019 оны 12 дугаар сарын хурлаар хэлэлцүүлэн батлуулсан болно.

- 1.1 Төслийн байршил, мэдээлэл

Тухайн төслийн талбай нь Засаг захиргааны нэгжийн хуваариар Өмнөговь аймгийн Гурвантэс суманд харъяалагдах ба сумын төвөөс урагш 40 км, Шивээхүрэнгийн боомтоос 45 км-т оршино. Мөн тусгай зөвшөөрлийн талбай нь “Монголын алт (МАК)” ХХК-ийн Нарийн сухайт, “Саусгоби Сэндс” ХХК-ний Овоот Толгой, “Өсөх Зоос” ХХК-ийн “Хүрэн Шанд” нүүрсний уурхайн ашиглалтын талбайгаас хойд зүгт 2 км зайд байрлана.




*Зураг 1. Төслийн байршил*

- 1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын товч мэдээлэл:

| Төслийн нэр | Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч | “Чухамжаргалан” ХХК |
| Бүртгэлийн дугаар | 1111003044 |
| Рсгистрийн дугаар | 3614093 |
| Ашигт малтмал ашиглалтын тусгай | SGMY-00009 |
| Талбайн хэмжээ | 103.9 га |
| Төслийн зорилго, ач холбогдол | “Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл нь Монгол улсын стандартад нийцсэн дайрга үйлдвэрлэх улмаар Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн хүрээнд эдийн засгийн үр ашиггайгаар, иж бүрэн ашиглах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, байгаль орчинд сөрөг нөлөө багатай үйл ажиллагаа явуулж нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байрууд бий болгож нийгэм-эдийн засгийн үр өгөөжийг өндөр байлгахад төслийн үндсэн зорилго оршино. |
| Тосөл хэрэгжүүлэгчийн хаяг | “Өмнөговь аймаг, Гурвантэс сум, Урт баг |
| Төслийн байршил | Өмнөговь аймаг, Гурвантэс сум, Урт баг, Хөв нэртэй |
| Чухамжаргалан ХХК захирал | А.Тэмүүлин |

- 1.3 Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал

Барилгын чулууны ордын уурхай, үйлдвэрийн барилга байгууламж, ашиглалтын үеийн үйл ажиллагаанд шаардагдах ус, эрчим хүчний хангамж, засвар үйлчилгээ зэрэг дэд бүтцийн шийдлийг энэ бүлэгт тусгалаа.

***1.3.1. Барилга байгууламжийн ерөнхий төлөвлөгөө***

Уурхай. үйлдвэрийн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн баруун урд талд байрлана.

*Хүснэгт 1. Барилга, байгууламж, хийц бүтэц*

| № | Нэр | Хийц, бүрдэл | Тоо, ш |
|---|---|---|---|
| 1 | Оффис, ажилчдын байр | Зөөврийн байгууламж | 3 |
| 2 | Засварын газар, материалын | Чингэлэг | 1 |
| 3 | Түлшний агуулах сав | Иж бүрэн | 1 |
| | Дүн | | 5 |

Машин техник, тоног төхөөрмжийн завсар үйлчилгээ

Ил уурхайд жижиг засварын газрыг барьж байгуулна. Уурхайн машин техник, үйлдвэрийн тоног төхөөрмжийн засвар үйлчилгээг өөрийн засварын мэргэжилтнүүд хийж гүйцэтгэнэ. Засварын хэсэгт дугуй засвар, гагнуур, компрессор зэргийг суурилуулна.

Шатах тослох материалын агуулах

Түлш хадгалах зориулалтаар 5-10 тонны багтаамжтай ган сав 1 ширхэгийг, дизелийн масло болон бусад тос материалыг зориулалтын савтай нь тус тус хадгална. ШТМ-ын гал аюулгүй байдлын шаардлага, норм дүрмийн дагуу байрлуулан зориулалтын тоноглолоор хангасан байна.

### *1.3.2. Усан хангамж*

*Унд ахуйн усан хангамж*

Энэхүү төслийг ашиглах үед нэг ээлжиинд нийт 18 хүн жилд 220 өдөр ажиллаж (хүйтэн нөхцөлд ажиллахгүй жилд 7 сар ажиллана) амьдрахаар унд ахуйн хэрэглээний усны хэрэгцээг тооцсон. Унд ахуйн усны хэрэгцээнд шаардлагатай усыг гүний худгаас хангах бөгөөд ажилчдын өдөр бүрийн хэрэглээнд савлагаатай цэвэр усаар хангана. Жилд унд ахуйн хэрэгцээнд шаардлагатай усыг тооцохдоо Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12-р хавсралт Орон сууц нийтийн байр, гэр хорооллын усны нормын дагуу тооцож гаргасан 316.8$м^3$ ус ашиглана.

*Хүснэгт 2. Кемпийн унд ахуйн усны хэрэглээ*

| № | Орон сууц нийтийн байр, гэр хорооллын усны норм | Ус хэрэглээнд хоногийн дундаж норм, л/хоног/хүн | Ажилчдын тоо | Төслийн жилд ажиллах хоног | Нийт хэрэглээ $м^3$ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон нийтийн байр | 80 | 10 | 220 | 176,0 |

*Уурхайн усны хэрэглээ*

*Хүснэгт 3. Замын тоос дарахад ашиглах усны хэмжээ*

| Ашиглалтын жилүүд | Замын хэмжээ | | | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2015 оны 07-р сарын | | | Нэг удаа за… | Усалгааны давтамж | Нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Усалгааны | Зорчих хэсгийн | Талбай $м^2$ | Усалгааны төрөл | Хэмжих нэгж | Усалгааны норм литр | | | Өдөрт ашиглах усны, $м^3$ | Жилд /220 хоног/ хэрэглэх усны хэмжээ $м^3$ |
| 1 | 150 | 30 | 225 | Зам | $м^2$ | 2 | 4500 | 5 | 22. | 4950 |
| 2 | 170 | 15 | 225 | Зам | $м^2$ | 2 | 4500 | 5 | 22. | 4950 |
| 3 | 170 | 15 | 225 | Зам | $м^2$ | 2 | 4500 | 5 | 22. | 4950 |
| 4 | 170 | 15 | 225 | Зам | $м^2$ | 2 | 4500 | 5 | 22. | 4950 |
| 5 | 170 | 15 | 225 | Зам | $м^2$ | 2 | 4500 | 5 | 22. | 4950 |
| Нийт | | | | | | | | | | 24750 |

*Нөхөн сэргээлтэнд ашиглах усны хэрэглээ*

*Хүснэгт 4. Нөхөн сэргээлтэнд ашиглах усны хэмжээ*

| Ашиглалтын жилүүд | Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ $м^2$ | | | Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301-р тушаалын 13-р хавсралт | | | Нэг удаа усалгаанд зарцуулах усны хэмжээ | Усалгааны давтамж | Нийт хэрэглэх ус, $м^3$ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Усалгааны төрөл | Хэмжих нэгж | Усалгааны норм литр | | | |
| 3 | 20000 | | | Бут, сөөг | $м^2$ | 4 | 80 $м^3$ | 30 | 2400 |
| 4 | | 20000 | | Бут, сөөг | $м^2$ | 4 | 80 $м^3$ | 30 | 2400 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | | 20000 | Бут, сөөг | $м^2$ | 4 | 80 $м^3$ | 30 | 2400 |
| Уурхайн хаалт 38000 | | | | Бут, сөөг | $м^2$ | 4 | 152 | 30 | 4560 |
| Нийт | | | | | | | | | 11760 |

*Хүснэгт 5. Төсөлд ашиглагдах нийт усны хэмжээ*

| Ашиглалтын жил | Ил уурхайд шаардлаг агай усны хэрэглээ | Хотхонд шаардлагатай усны хэрэглээ | Нөхөн сэргээлтэнд | Нийт |
|---|---|---|---|---|
| | $м^3$/жил | | | |
| 1 | 4950 | 176,0 | - | 5126 |
| 2 | 4950 | 176,0 | - | 5126 |
| 3 | 4950 | 176,0 | 2400 | 7526 |
| 4 | 4950 | 176,0 | 2400 | 7526 |
| 5 | 4950 | 176,0 | 2400 | 7526 |
| 6 | - | - | 4560 | 4560 |
| | 24750 | 1056 | 11760 | 37566 |

Төслийн жилд зарцуулах цэвэр усны хэмжээ эхний 2 жилд 10,256 $м^3$, сүүлийн 3 жилд 22,578$м^3$, хаалтын нөхөн сэргээлтийн 1 жилд 4560 $м^3$ тус тус байна. Төсөл хэрэгжүүлэгч Чухамжаргалан ХХК нь энэ оноос усан хангамжийн гүний худаг гаргахаар төлөвлөсөн бөгөөд худаг гарах хүртэл хугацаанд шаардлагатай усыг Гурвантэс сумын орон нутгийн өмчид худгаас зөөврийн байдлаар ашиглахаар болсон.

### *1.3.3. Цахилгаан хангамж*

Хөв барилгын чулууны орд нь ӨБЦД шугамаас 4 км зайд байрлах бөгөөд тус эрчим хүчний байнгын эх үүсвэрээс 6/0.4 кВ агаарын цахилгаан дамжуулах шугам татаж 400 кВА трансформатор суурилуулсан байна.

*Хүснэгт 6. Цахилгааны хэрэгцээний тооцоо*

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Марк | Тоо ширхэг | Нэгжийн чадал, кВт | Нийт чадал, кВт | Тооцооны чадал, кВт | Цахилгааны хэрэгцээ, кВт.цаг |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тосгоны | | 1 | 10 | 10 | 7.5 | 11,475 |
| 2 | Засварын газрын хэрэглээ | | 1 | 15 | 15 | 10.5 | 30,450 |
| 3 | Ангилан бутах хэсэг | | | | | | |
| 3.1 | Чичиргээт тэжээгч | ZSW-490x110 | 1 | 15 | 15 | 11.3 | 17,213 |
| 3.2 | Хацарт бутлуур | PE800x1060 | 1 | 75 | 75 | 56.3 | 86,063 |
| 3.3 | Конусан бутлуур | CC-1380C | 1 | 30 | 30 | 22.5 | 34,425 |
| 3.4 | Конусан бутлуур жижиг | CC-1300C | 1 | 30 | 30 | 22.5 | 34,425 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Чичиргээт шигшүүр | 2ҮК2460 | 2 | 35 | 70 | 52.5 | 80.325 |
| 3.6 | Туузан конвейер | | 10 | 5.5 | 55 | 41.3 | 63,113 |
| Нийт | | | | 190.5 | 275 | 224.3 | 357,488 |




*Зураг 2. Цахилгаан хангамжын трассын зураг*

- **1.4 Төсөл хэрэгжих хугацаа, хүчин чадал**

Ордын нөөцийг бодитой (B) зэргээр 442.77 мян.м3, боломжтой (C) зэргээр 145.00 мян.м3, нийт (B+C) 587.77 мян.м3 гэж Эрдэс баялаг, мэргэжлийн зөвлөлөөр 2018 онд батлуулжээ (ЭБМЗ-ийн дүгнэлт, дугаар XX-12-04).

Энэхүү батлагдсан нөөцөд үндэслэн Өмнөговь аймгийн Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31 -ны өдрийн А/1537 дугаар захирамжаар тус аймгийн Г урвантэс сумын Урт багийн Хөв нэртэй газар орших 103.9 гектар талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын SGMV- 00009 тоот тусгай зөвшөөрлийг Чухамжаргалан ХХК-д олгосон.

Батлагдсан нөөц, тусгай зөвшөөрлийн мэдээлэл, Чухамжаргалан ХХК-ийн Техникийн даалгаварт үндэслэн, техник-эдийн засгийн үндэслэлийг Майндата ХХК боловсруулж, ЭБМЗ- өөр хэлэлцүүлэн 2019 оны 06 сарын 27-ны өдрийн Т/19-11-07 тоот дүгнэлтүүдийг үндэслэн АМГТГ-ын даргын 2019 оны 08 сарын 07-ны өдрийн Т/126 тоот тушаалаар ТЭЗҮ-г батлуулан ажилласан.

Түгээмэл тархацтай ашигт малтал Хөв нэртэй ордод “Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл” 5 жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд жилд 88 мян.$м^3$ дайрга олборлох хүчин чадалтай болно. Ил уурхай нь улирлын чанартай дулааны улирал 7 сарын хугацаанд жилд 220 хоног, хоногт 2 ээлж, ээлжинд 12 цагаар ажиллана. Энэхүү төсөлд 11 албан тушаалд 24 хүн ажиллахаар төлөвлөсөн болно.

Уурхайн ашиглалтын хугацаанд ил уурхайгаас 138.6 мян.м3 хөрс хуулж, 426.8 мян.м3 барилгын чулуу олборлоно. Хөрс хуулалтын коэффициент (Кхх)=0.20 м3/тн байна.Хөв ордын барилгын чулуу нь физик механикийн шинжилгээгээр профессор Протодъяконовын ангиллаар 1=9 хатуулагтай байна. Иймээс уулын ажлыг жигд найдвартай явуулахын тулд өрөмдлөг тэсэлгээний ажлаар чулууг урьдчилан сийрэгжүүлэх шаардлагатай бөгөөд жилд дунджаар 11.5 мян.м/жил өрөмдлөгийн ажил гүйцэтгэж, 16 удаа тэсэлгээ хийхээр тооцсон.

Хөрс хуулалт, олборлолтонд ажиллах экскаваторыг 1.1 м3 утгуурын багтаамжтай экскаватор гүйцэтгэх бөгөөд 15 тн-ийн даацтай HOWO загварын автосамосвал тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгэнэ. Мөн $3м^3$ багтаамжтай ачигч анхдагч дайргыг бутлуурт хийж түүнээс төслийн эцсийн бүтээгдэхүүн гарах бөгөөд ашиглалтын 5 жилийн хугацаанд 418.0мян.м3 дайрга үйлдвэрлэнэ.

- **1.5 Төслийн үр ашиг**

Төслийн 5 жилийн хугацаанд борлуулалтын орлого 11,076 сая төгрөг, үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал 7,499 сая төгрөг ба аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дараах цэвэр ашиг 3,219 сая төгрөг болж байна. Төслийн ашиглалтын хугацаанд үйл ажиллагааны мөнгөн урсгал 4,339 сая төгрөг ба өссөн дүнгээр 2,401 сая төгрөгний ашигтай ажиллахаар байна.

Төслийн хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 2.3 жил, өгөөжийн дотоод норм (IRR) 33.6 Өнөөгийн үнэ цэнэ (NPV@10) 1,336 сая төгрөг гарч байна. Төслийн үр ашгийн тооцоог дараах хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 7. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Ашиглалтын жилүүд | | | | | | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 0 | 1 жил | 2 жил | 3 жил | 4 жил | 5 жил | |
| 1 | Боруулалтын хэмжээ | $м^3$ | | 86,184 | 86,184 | 86,184 | 86,184 | 73,226 | 417,960.6 |
| 2 | Боруулалтын үнэ | $төг/м^3$ | | 26,500 | 26,500 | 26,500 | 26,500 | 26,500 | |
| 3 | Боруулалтын орлого | сая төг | | 2,283.9 | 2,283.9 | 2,283.9 | 2,283.9 | 1,940.5 | 11,076.0 |
| 4 | Үйл ажиллагааны зардал | сая төг | | 1,464.6 | 1,194.0 | 1,184.8 | 1,163.1 | 1,049.5 | 6,056.0 |
| 5 | Татвар, төлбөрүүд | сая төг | | 296.8 | 296.5 | 296.4 | 296.4 | 257.3 | 1,443.3 |
| 5.1 | Үүнээс: Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, | сая төг | | 57.1 | 57.1 | 57.1 | 57.1 | 48.5 | 276.9 |
| 5.2 | Нэмэгдсэн өртгийн албан татвар, 10% | сая төг | | 202.4 | 202.4 | 202.4 | 202.4 | 172.0 | 981.7 |
| 6 | Нийт үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал | сая төг | | 1,761.4 | 1,490.5 | 1,481.2 | 1,459.5 | 1,306.8 | 7,499.3 |
| 7 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өмнөх ашиг | сая төг | | 522.5 | 793.4 | 802.6 | 824.4 | 633.7 | 3,576.6 |
| 8 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | сая төг | | 52.3 | 79.3 | 80.3 | 82.4 | 63.4 | 357.7 |
| 9 | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дараах цэвэр | сая төг | | 470.3 | 714.0 | 722.4 | 741.9 | 570.4 | 3,219.0 |
| 10 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл | сая төг | | 213.1 | 213.1 | 213.1 | 213.1 | 213.1 | 1,065.3 |
| 11 | Геологийн хайгуулын ажлын шингээсэн зардал | сая төг | | 20.0 | 20.0 | 15.0 | | | 55.0 |
| 12 | Үйл ажиллагааны мөнгөн урсгал | сая төг | | 703.3 | 947.1 | 950.4 | 955.0 | 783.4 | 4,339.2 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал | сая төг | -1,938.0 | | | | | | -1,938.0 |
| 14 | Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал, (үлдэгдэл) | сая төг | | | | | | | 0.0 |
| 15 | Цэвэр мөнгөн урсгал, (жил бүрийн) | сая төг | -1,938.0 | 703.3 | 947.1 | 950.4 | 955.0 | 783.4 | 2,401.2 |
| 16 | Цэвэр мөнгөн урсгал,(өссөн дүнгээр) | сая төг | | -1,234.7 | -287.6 | 662.8 | 1,617.8 | 2,401.2 | |
| 17 | Барилгын чулууны дундаж өртөг | мян.төг/м 3 | | 21.0 | 18.2 | 18.1 | 17.9 | 18.7 | |

- **1.6 Төслийн техник тоног төхөөрөмж**

Төслийн үйл ажиллагаанд 1 экскаватор, 4 автосамосвал, 1 дугуйт утгуурт ачигч, бутлуур, суудлын машин, 1 усны машин зэрэг хөдөлгөөнт болон суурин тоног төхөөрөмж ажиллана.

Барилгын чулууны ордын жилийн хүчин чадал бага ба үүнтэй уялдан уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүдийг бага болон дунд хүчин чадалтай байхаар сонгосон. Ил уурхайн хөрс болон хүдрийг өрөмдлөг тэсэлгээний аргаар сийрэгжүүлж, хөрс хуулалт болон хүдэр олборлолтонд CAT 336 маркийн экскаватор, хөрс, хүдэр тээвэрт 15м$^3$ тэвшний багтаамжтай, 20 тн даацтай HOWO маркийн автосамосвалуудыг тус тус ашиглана.









*Зураг 3. Төсөлд хэрэглэгдэх тоног төхөөрөмж*

- 1.7 Ажиллах хүчний тухай мэдээллүүд

Энэхүү төсөл 24 хүний ажлын байраар хангах бөгөөд нэг ээлжиндээ уурхайн талбайд 10 ажилтан ажиллана. Мөн энэхүү төсөл чанартай дулааны улирал 7 сарын хугацаанд жилд 220 хоног, хоногт 2 ээлж, ээлжинд 12 цагаар ажиллана.

*Хүснэгт 8. Нийт ажилчид*

| № | Албан тушаал | Нийт орон тоо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэх захирал | 1 |
| 2 | Үйл ажиллагаа хариуцсан захирал | 1 |
| 3 | Үйлдвэрийн дарга | 1 |
| 4 | Нягтлан бодогч | 1 |
| 5 | Байгаль орчны мэргэжилтэн | 1 |
| 6 | Экскаваторын оператор | 2 |
| 7 | Автосамосвалын оператор | 4 |
| 8 | Ачигчийн оператор | 4 |
| 9 | Үйлдвэрийн оператор | 2 |
| 10 | Туслах | 5 |
| 11 | Гагнуурчин | 2 |
| Нийт орон тоо | | 24 |

- **1.8 Уурхайн технологийн дараалал**

***<u>Уурхайн олборлолт</u>***

Уурхайн хүчин чадлыг "Чухамжаргалан" ХХК-ийн техникийн даалгаварыг харгалзан үзэж жилд 88 мян.м3 буюу 231.4 мян.тн барилгын чулуу олборлохоор техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан бөгөөд 5 жилийн хугацаатай хэрэгжих төсөл юм.

Ил уурхайн хөрс хуулалт, барилгын чулуу олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ - ухаж ачих ажиллагаа - автотээвэр - гадаад овоолго гэсэн дарааллаар гүйцэтгэнэ.

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2 метрээс ихгүй зузаантайгаар сийрэгжилтийн ажлыг хийлгүйгээр экскаватораар ухаж уурхайн хүрээнээс 15-20 метрийн зайнд байршуулна.

Хөрс хуулалтын ажил: Хөрсийг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлсний дараа ухан ачиж, хөрсний гадааад овоолгод шилжүүлнэ. Хөрсний

догол нь 5 метрий өндөртэй. Ил уурхайн хөрс хуулалтанд 1.1 м3-ийн шанаганы багтаамжтай Hundai ROBEX-2800 экскаватор, 15 тн даацтай HOWO маркийн автосамосвалын хослол ажиллана.

***Бутлуур***

Хөв барилгын чулуу боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд нь үйлдвэрийн талбайд бэлэн байгааа захиалагчийн техникийн даалгаварт өгөгдсөн хүчин чадлыг үндэслэн тоног төхөөрөмжийн хүчин чадлын тооцоолол, бүтээгдэхүүн гаргалтын хэмжээ зэргийг тооцов.

Барилгын чулуу бутлах технологи нь дараах үндсэн процессуудад хуваагдана. Үүнд:

- Бутлуур
- Шигших дамжлага
- Бүтээгдэхүүний овоолго
- Бэлэн бүтээгдэхүүний чанарын хяналт.




*Зураг 4. Барилгын чулуу бутлах технологийн схем*

- **1.9 Тухайн жилийн уурхайн ашиглалтын төлөвлөгөө**

Уурхайн ашиглалтын хугацаанд ил уурхайгаас 138.6 мян.$м^3$ хөрс хуулж, 426.8 мян.$м^3$ барилгын чулуу олборлоно. Хөрс хуулалтын коэффициент (Кхх)=0.20 $м^3$/тн байна.

Хөрс хуулалтын ажил нь нөөцийг бүрэн олборлохын тулд уурхай хүрээ тэлэлтээс үүдэн нөөцийн блокийн эргэн тойронд явагдахаар байна. Хөрсний чулуулгийн шинж чанар нь барилгын чулуутай ижил үзүүлэлтэй байгаа тул ашиглалтын явцад нөөцийг нэмэгдүүлэх

боломжтой байна.

*Зураг 5. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Ашиглалтын жил | | | | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 жил | 2 жил | 3 жил | 4 жил | 5 жил | |
| 1 | Хөрс хуулалт | мян.$м^3$ | 75.1 | 21.2 | 18.8 | 16.3 | 7.2 | 138.6 |
| 2 | Дайрга олборлолт | мян.$м^3$ | 88.00 | 88.00 | 88.00 | 88.00 | 74.6 | 426.8 |
| 3 | Уулын цул | мян.$м^3$ | 163.14 | 109.2 | 106.8 | 104.3 | 81.8 | 565.4 |
| 4 | Хөрс хуулалтын коэффициент | $м^3/м^3$ | 0.85 | 0.24 | 0.21 | 0.18 | 0.09 | 0.33 |

# 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

## 2.1. Уур амьсгал

Төсөл хэрэгжих газар нутаг нь Монгол орны цөлийн болон цөлөрхөг хээрийн бүсийн эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвөл -15-200С хүйтэрч, зун +30 -350С заримдаа +400С хүрч халдаг. Жилийн агаарын дундаж температур +2-50С байна. Жилийн дундажаар салхигүй өдрийн тоо 10-15 хоног. Хамгийн их салхи хавар, намар тохиолдох бөгөөд дунджаар 5.9 м/сек, хамгийн бага салхитай улирал нь өвөл бөгөөд салхины хурд дунджаар 4.2-4.3 м/сек. Жилийн 30-35 хоног 15 м/сек хүртэл хүчтэй цасан ба шороон шуурга тавина. Хөрсний хувьд говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд багтдаг.

Хур тунадас маш бага, өвөл 0-3 мм, зун 30-60 мм, жилд 100 мм-ээс бага тунадас унадагийн 80% нь 7-8 сард оногдоно. Өвлийн 100 орчим хоногт 1-2 см, хамгийн их нь 10 см орчим цоохор цастай байдаг.

## 2.2. Агаарын чанар

Төслийн талбайд одоогийн байдлаар бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа тул техникийн хөдөлгөөний улмаас талбайн хөрс эвдэгдэж улмаар тоосжилт бий болон нөхцөл бүрдсэн байдалтай байна. Төсөл хэрэгжиж буй газар нь Нарийн сухайтын бүлэг нүүрсний ордоос 2 км зайд байрладаг. Иймд энэ бүс нутагт хэрэгжиж буй уул уурхайн төслүүдтэй холбоотойгоор нутгийн агаарын чанарын байдал өөрчлөлт орох болзошгүй юм. Иймээс агаарын чанарыг тодорхойлохдоо уурхайгаас гарч буй тоосжилтонд гол ач холбогдол өгөх нь чухал бөгөөд түүнчлэн төслийн талбай нь байгалийн хөрсний тогтоц,

уур амьсгалын нөхцөл, ургамлан нөмрөгийн байдлаасаа шалтгаалж байгалийн нөхцөлөөрөө тоосжилт үүсэх эмзэг бүс болоод байгаа. Мөн энэхүү төслийн үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, өрөмдлөг, тэсэлгээ, ил задгай хөрснөөс хийссэн тоосжилт үүсэх боломжтой юм.

Нарийн сухайтын бүлэг ордод зэргэлдээ орших аж ахуйн нэгжүүд 2016-2018 хүртэл Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж ирсэн. Тус ажлын агаарын чанарын үр дүнгээс харахад уурхайлалт хийж буй бусад газарт агаарын чанарыг стандарттай харьцуулахад бүх хугацаанд давсан үзүүлэлтгүй байна.

## 2.3. Гадаргын ус

Төслийн талбай орчимд 2 булаг шанд оршдог бөгөөд эдгээр нь тухайн үеийн судалгааны үед (2019 оны 03-р сард) илэрцийн эхнээс эхлэн байнгын урсгалтай байвч урсацын явцад хуурай сайрд шингэн урсацгүй болж байв. Эдгээрээс Сухантын гол булаг нь нилээд гадаргуугийн урсацтай байгаа нь тогтоогдсон. Төслийн талбайгаас зүүн урагш 10км зайд байрлана. Сухантын гол Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натри-кальцийн бүлгийн 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Гадаргын усны цэврийн зэргийн ангилалын норм"-ын дагуу "Цэвэр" гэсэн ангилалд хамаарч байна. Усны орчинд өөрчлөлт гараагүй шүлтлэг буюу PH долоогоос их байна.

Судалгааны явцад ундаргыг хөөврийн аргаар тодорхойлоход 12 л/сек байлаа. Өмнөх судалгаагаар 15 л/с байжээ. Голын усыг хиймэл баянбүрдийг (шугуйг) услахад ашиглаж байна.

## 2.4. Газрын доорх ус

Төсөл хэрэгжих бүс нутаг нь Ноёны мегаантиклиналь бүтцийн урд жигүүрээр Овоотын бүтэц- эвшлийн бүсийн Овоотын хагарлын бүсийн дагуу зурваслан тархах дээд пермийн нүүрслэг хурдсын тархалтын талбайд байрлана.

Уг орд болон түүний зэргэлдээх талбайд давхрага зүйн ангиллын дагуу дээд пермийн дэлийн шандын (P2ds), дунд-дээд триасын ноёны (T2-3no) давхрагадасуудын ба дунд-дээд юрын, түүнчлэн дөрөвдөгчийн (Q) хурдаст тархсан уст цогцолборууд ялгагдана.

Бүс нутгийн хэмжээнд бүрэлдэн бий болсон газрын доорх урсац хагарлын бүс дагуу өгсүүр шүүрэлт үүсгэх ба урсацын зарим хэсэг уг хагарал дагуух газрын доорх усны алдагдлын бүсэд өндөр усжилт үүсгэн, нөгөө хэсэг нь газрын нам хэсэг рүү далд

урсац хэлбэрээр алдагдан уг хагарлын бүс дагуу усан солилцооны эрчим өндөртэй бүс үүсдэг байна. Овоотын усажсан хагарлын дагуу олон тооны булгууд шургасан байдлаар ихэвчлэн дөрөвдөгчийн хурдас тархсан талбайд илэрдэг. Мөн энэ хэсгүүдийн орчимд гар худгууд элбэгтэй. Тухайлбал, Хүрэн- овоогийн, Зүүн чацгат, Баруун чацгат, Тойрон шандын, "Улаан" овоогийн, Зүүн хөвийн г. м. гар худгууд байна.

Баруун чацгатын малчны худаг: Худгийн ус химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонат-хлорын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү зөөлөвтөр ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс зөвхөн магнийн ион "Монгол улсын ундны усны чанарын стандарт MNS 900-2010"-д заасан хэмжээнээс (30 мг/л) ялимгүй их байна. Химийн найрлагаар гидрокарбонат-хлор-сульфат-нартийн найрлагатай, цэнгэг, бага хатуулагтай, шүлтлэг орчинтой газрын доорх ус байна. Өмнөх судалгааны өгөгдлүүдтэй харьцуулахад онцын өөрчлөлт ажиглагдахгүй болно. Худгийн газрын доорх усны түвшин газрын гадаргаас 0.51 м-ийн гүнд байрлана. 2012 оны хэмжилтээр 1.45 м гүнд усны түвшинд байна гэсэн тэмдэглэл байна. Ү үнээс үзэхэд усны түвшин 0.94 м-ээр нэмэгдсэн байна.

Зүүн хөв худаг: Зүүн хөвийн худгийн усны түвшин хэмжилтээр 1.69 м. гүнд байгаа нь тогтоогдсон. Үүнийг 2012 оны хэмжилттэй харьцуулахад (1.47 м) 0.22 м-ээр усны түвшин буурсан байна. Физик шинжээр тунгалаг, үнэр, амтгүй байлаа. Химийн бүрэлдэхүүнээрээ О. А. Алекиний ангиллаар гидрокарбонатын ангийн, натри-кальцийн бүлгийн, 2-р төрлийн, цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна.

### 2.5. Хөрсөн бүрхэвч

Төсөл хэрэгжих газрын хөрсөн бүрхэвч нь хөрс-газарзүйн мужлалаар Алтайн чанад дахь говь цөлийн жинхэнэ цөлийн хөрсний бүсэд багтаж говийн мужийн говийн цайвар бор, цөлийн бор саарал хөрс бүхий XII тойрогт багтана.

Иймд тус газарт цөлийн бор хөрс, цөлийн бор саарал хөрсний хэв шинжүүд ноёлж тэгшивтэр газарт нь цөлийн бор хөрсний 4 төрөл, цөлийн цайвар бор хөрсний 3 төрөл, цөлийн бор саарал хөрсний 3 төрөл тархах бол уул цав толгодоор нь уул толгодын цайвар бор хөрсний 2 төрөл, нам дор хотгордуу газраа заримдаг цөлийн далд глейрхэг хөрс тархана. Тэгвэл яг төсөл хэрэгжих газарт нам бэсрэг толгодоор нь уул толгодын бор хөрс, тэгшивтэр хөндийгөөр нь цөлийн бор хөрс, цөлийн бор саарал хөрс тархсан байв.

Физик шинжээр тунгалаг, үнэр, амтгүй болно.Ургамлан бүрхэвч

Төслийн талбай нь ургамал газарзүйн мужлалаар Евроазийн хээрийн муж, Умард говийн цөлийн хээрийн провинци, Говь-Алтайн уулархаг цөлийн хээрийн тойрог, Сэврэй, Эхэн Зулганайн районд хамагдана /А. А. Юнатов/. Харин Грубовын /1982он/ ангиллаар Алашаа говийн тойрогт хамаарах бол "Монгол улсын үндэсний атлас"-д Сахар-Говийн цөлийн хэвшинжийн мужийн Төв Азийн дэд мужийн Умард Төв Говийн хошууны Овоотын тойрогт хамаарна /2009/ гэжээ. Тэгвэл манай нэрт эрдэмтэн Л.Өлзийхутаг гуайн ангилалаар бол Монгол-Алтайн уулын хээр, Алтай өвөр говийн /цөлийн/ тойргуудад хамааргадана /.Л.Өлзийхутаг, 1978/. Ер нь тухайн бүс нутаг нь газрын хотгор гүдгэрийн хувьд хаяа уулсын алсаас налуу бэл, хормойд байрлах учир сайр садаргаар маш их хэрчигдсэн боловч ул чулуулаг нь Нарийн сухайтын булагийн хотгорт хамаарах эртний нуурын хотгор учир ихэнхидээ хужир мараа ихтэй хөрстэй тул ургамлан нөмрөг ихэвчлэн давс-хужирт гарлын ургамлын төрөл зүйлээс бүрдсэн байна. Харин сайр хотгоруудын хоорон дохь дэнж, дэвсэг газрууд бараг ургамалгүй нүцгэн шахуу байх бөгөөд энд ургамлан нөмрөгийн бүрхэц ихэвчлэн 1-5% байна. Мөн ганц нэг тоорой үзэгдэнэ.

### 2.6. Амьтны аймаг

Энэ төсөл орших Нарийн сухайтын сав газар нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Говь Алтай уулын тойрог, Алашаа говийн цөлийн тойрогт багтдаг. Иймд төслийн талбайн хойд бие үргэлжилсэн цавчим өндөр хадархаг уулсаар хүрээлэгдсэн бол талбайн урд хэсэг нам, хайргархаг бэсрэг толгод, тэгш талархаг гадаргуутай, талбайн хүрээнд байнгын урсацтай булаг, шанд уст цэгүүд олон тул амьтны зүйлийн тооны хувьд харьцангуй баялаг газар юм.

Уурхайн лицензийн талбай түүний ойр орчмоор байгаль тайлан, түүний нэмэлт тодотголууд, мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлсэн судалгаанаас харахад нийт 22 зүйлийн хөхтөн, 86 зүйл нүүдлийн болон суурин шувуу, 8 зүйлийн мөлхөгчид, хоёр нутагтан, 91 зүйлийн сээр нуруугүйтэн бүртгэгдсэн байна.

**Түүх соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутаг**: Төсөл хэрэгжих газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс одоогоор илрээгүй /Овоот Толгой уурхайн археологийн судалгааны тайлан/ байгаа бөгөөд хэрвээ илэрвэл тэр даруйд нь холбогдох төрийн захиргааны төв байгууллагад мэдээллэх үүрэгтэй.

Тус төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн

тусгай хамгаалалтын газар нутагтай давхцалгүй байна.

**Нийгэм, эдийн засаг:**

Төсөлд орон нутгийн иргэд ажилд орох нөхцөл бүрэлдэж, улмаар сумын ажилгүйдлийн түвшин10 иргэнээр буурна, өрхийн амьжиргаа дээшлэх, өрхийн орлого нэмэгдэх, төслөөс орон нутагт татвар, хураамж, төлбөр хэлбэрээр орсон орлого сум, орон нутгийн хөгжилд зохих хэмжээгээр дэмжлэг болно. Харин нийгэм, эдийн засагт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийг авч үзвэл тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн тоосжилт, дуу шуугианаас үүдэн нутгийн иргэдэд тавгүй байдал үүсгэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх маргаан гарч болзошгүй. Иймд онц шаардлагагүйгээр олон салаа зам бий болгохоос зайлсхийх, замын тэмдэг, гэрэл ойлгогч зэргийг шаардлагатай газруудад байрлуулах, жолооч нарын сахилга батыг уурхайн дотоод журамд тусгах ба тогтмол хянах, 20:00-07:00 цагийн хооронд аливаа тэсэлгээ болон дуу чимээ их гаргах үйл ажиллагаа явуулахгүй байх. Төслийн талбай хээрийн судалгаа хийж байхад ойролцоох айл өрхүүд байгаль орчныг бохирдуулахгүй байх, тоосжилтыг маш сайн хянах, бууруулах, хог хаягдалаа зориулалтын цэг дээр хаях, тус нутагт байгаль хамгаалалттай холбоотой хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг дэмжиж ажиллах, холбогдох хууль журмыг чанд мөрдөж, стандарт журмын дагуу ажиллах хэрэгтэй гэсэн санал хүсэлтийг хэлж байсан.

Оршин суугчид нөлөөллийн бүсийн гадна талд байрлах учир газар ашиглалтын эрх зөрчигдөхгүй. Төсөл хэрэгжсэнээр ажлын байр бий болж, нутгийн иргэд ажилд орно. Хамгийн ойрын суурин нөлөөллийн бүсийн гадна талд байрлах тул сөрөг нөлөөлөлд өртөхгүй. Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэхгүй. Энэхүү төсөл хэрэгжиснээр 5 жилийн хугацаанд улс, орон нутгийн төсөвт төлөх татварын хэмжээ 1,443.3 сая төгрөг болно.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь барилга байгууламж барих овоолго үүсгэх зэрэг ажлыг гүйцэтгэхэд 9.8 га талбай хөндөгдөж нөлөөлөлд өртөхөөр байна.

- 3.1. Төслийн болзошгүй нөлөөлөл

Төслөөс байгаль орчны бүрэлдэхүүнд тус бүрт үзүүлж болзошгүй нөлөөлөл

| № | Үзүүлэлт | Нөлөөллийн түвшин | Тайлбар |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Газрын хэвлий рельеф | Их | Ажлын үед шинээр хөрс хуулах, уурхайлалтын ажил хийгдэх тул энэ төрлийн нөлөөлөл их гэж үзлээ. Нийт 1.7 га талбайд 40метр гүнтэй ухлага үүснэ |
| 2 | Цаг уур, уур амьсгал | Дунд | Цаг агаарын нөхцөл байдал төслийн үйл ажиллагаатай шууд хамааралтай байдаг бөгөөд цаг уурын таагүй /үер, салхи/ байдлаас төслийн ажил зогсох, удаашрах зэргээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хугацаа уртасна. Хүчтэй салхи, шороон шуургаар ил задгай барилгын болон ажилчдын хог хаягдал хийсч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлж болзошгүй. |
| 3 | Агаарын чанар | Бага | Төслийн үйл ажиллагаа, техник тоног төхөөрөмжийн хөдөлгөөний үйл ажиллагаанаас тоос шороо үүснэ. Төслийн талбайд ажиллах техникүүдийн түлшний шаталтаас хүлэмжийн хий ялгарна. |
| 4 | Усан орчин | Бага | Төслийн талбайн нөлөөллийн бүсэд гадаргын уст цэг байхгүй тул нөлөөлөл үзүүлэхгүй, гүний усны түвшинд төслийн ажил явагдахгүй учраас нөлөөлөхгүй. |
| 5 | Хөрс, газрын гадарга | Их | Төслийн үед хөрс хуулалт, газар шорооны ажил барилгажих талбайн хэмжээгээр хийгдэх тул энд үзүүлэх нөлөөллийг их зэрэг гэж үзсэн. |
| 6 | Ургамал | Их | Төслийн ажил явагдах талбай нь барилгажаагүй, техноген нөлөөлөлд өртөөгүй талбай байна. Уг талбай нөлөөлөлд өртөх тул энэ нөлөөллийн эрчим их байна. |
| 7 | Амьтан | Дунд | Төслийн талбай нь суурин газар учир хүн болон техникийн хөдөлгөөн, дуу чимээ ихтэй тул мэрэгч амьтад болон бор шувууны багийн жижиг шувууд болон синнантроп зүйлүүдээс бусад амьтад ерөнхийдөө шилжилт хөдөлгөөн хийнэ. Тос тосолгооны асгаралтын үед дутуу цэвэрлэхэд |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Дуу чимээ, доргилт, чичиргээ | Бага | Төслийн ашиглалтын үед, ачих, тээвэрлэлт тэсэлгээ зэргээс үүсэх дуу чимээ, чичиргээ нь ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй. |
| 9 | Үнэр | Дунд | Ажлын байрны орчин нь агаарын бохирдолтой тоосжилтой бүс тул ажилчдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл дунд. |

Төслийн үйл ажиллагаатай холбогдуулан байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг *нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлийн хэсгүүдтэй уялдуулан авч тодорхойлбол:*

*Хүснэгт 9. Төслийн үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өртөгдлийн байдал*

| № | Бохирдол, нолоөлөл | Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа) | Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| Нэг. Орчин | | | |
| 1.1 | Тоосжилт | Уурхайлалт, тэсэлгээ, тээвэрлэлт | • Төслийн талбай орчим тархах, ажилчдын эрүүл мэндийн байдалд нөлөөлнө |
| 1.2 | Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа | Тээвэрлэлтэнд хэрэглэгдэх машин, механизм | - Агаар орчинд тархах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал |
| Хоёр. Усан орчин | | | |
| 2.1 | Хатуу болон шингэн хог хаягдал | Ахуйн болон шатах тослох материалын хаягдал<br>Тээвэрлэлтийн явцад техникийн бүрэн бус байдал, хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас асгарах, гоожих | - Хур борооны усаар угаагдаж хөрс, гүний ус бохирдуулна |
| Гурав. Хөрс | | | |
| 3.1 | Эвдрэл | Байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс эвдрэл, элэгдэлд өртөгдөх, талхлагдах | - Хөрсний физик механик шинж чанарт өөрчлөлт орж болно.<br>-Үйл ажиллагааны хяналтаар нөлөөллийг бууруулах боломжтой. |
| 3.2 | Бохирдол | Шатах тослох материалын болон ахуйн хог хаягдлын асгаралт, болгоомжгүй байдлаас болзошгүй нөлөөлөл үүснэ. | - Хэмжээ хязгаарлагдмал<br>Хөрс бохирдсноос хөрсний шинж чанар, микробиологийн шинж чанарт өөрчлөлт орж болно<br>- - бохирдлоос сэргийлэх, бохирдох замыг хаалттай байлгах боломжтой. |
| Дөрөв. Ургамал бүрхэвч | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 4.1 | Газар шорооны ажлын үед | Ургамлан бүрхэвч бүхэлдээ устгагдах, дарагдах байдлаар үгүй болно. | - Хэмжээ хязгаарлагдмал<br>-Төрөл, зүйл устаж, өөрчлөгдөж болно |
| 4.2 | Талхлагдах | Техникийн хөдөлгөөнөөр үйл ажиллагаанд байнга өртөж буй зам, талбай, ашиглалтын объектуудын орчин | - Биомассын хэмжээ багасна<br>- Төрөл зүйл устаж болно<br>Нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно. |
| Тав. Нийгэм эдийн засгийн орчин | | | |
| 6.1 | Шинээр ажиллагсад авна | Эдийн засгийн чадавх дээшилнэ. Ажлын байр шинээр бий болно | - төсөл хэрэгжих хугацаанд |

Судалгаанаас үзэхэд тус энэхүү төслийн үйл ажиллагаа нь байгаль орчинд шууд ба шууд бус нөлөөллийн давхардсан байдлаар 22 нэр төрлийн нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Эдгээрээс улсын хэмжээнд нийгэм, эдийн засгийн чиглэлээр үзүүлж буй эерэг нөлөөлөл 6 байгаа бөгөөд үлдэх 18 хэлбэр нь сөрөг нөлөөлөлд хамаарна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг магадлан жагсаалтанд оруулан тэдгээрийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, нөлөөллийн байдал зэргийг нэгтгэн тодорхойлсноор ерөнхий дүр төрхийг харж болох юм. Мөн нөлөөллийн байдлыг дор дурьдсанаар авч үзэж болохоор байна.

*Хүснэгт 10. Болзошгүй нөлөөллийн магадлан жагсаалт*

| Байгаль орчны үзүүлэлт | Нөлөөлөл | | | Хугацаа | | Давталт | | Эрчим | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Шууд | Шуудбус | Өөрөө зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
| 1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт | | | | | | | | | | |
| Газрын доорх урсцын өөрчлөлт | | | | | | | | | | |
| Газрын доорх усны чанарын | | X | | | X | | | | | X |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ургамлын бүтцийн өөрчлөлт | | | | | | | | | | |
| Хөрсний элэгдэл, эвдрэл | X | | | | X | | X | | X | |
| Геологийн тогтоцын өөрчлөлт | | | | | | | | | | |
| Зэрлэг амьтдын орон зай | | | | | | | | | | |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт | | X | | | | | | | | X |
| 2. Байгалийн нөөц, ашиглалт | | | | | | | | | | |
| Газрын гадаргын нөөц баялаг | | | | | | | | | | |
| Бэлчээрийн байдал | | | | | | | | | | |
| Эрдэс түүхий эдийн нөөц | | | | | | | | | | |
| Эрчим хүчний нөөц | | X | | | X | | | | | X |
| 3. Байгаль, орчны өөрчлөлт | | | | | | | | | | |
| Ундны усны чанар, хэмжээ | X | | | | X | | X | | | X |
| Урсгал усны хэрэгцээ | | | | | | | | | | |
| Агаарын бохирдол | X | | | X | | | | | | X |
| Хөрсний эвдрэл, бохирдол | | X | | | X | | | | X | |
| Нефт бүтээгдэхүүнд агуулагдах хүнд металл хөрс, усаар дамжин | | X | | | X | | | | X | |
| Дуу чимээ, шуугианы нөлөө, | X | | | X | | | | | | X |
| 4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, Палентологийн олдвор | | | | | | | | | | |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх | | | | | | | | | | |
| Ландшафтын хэлбэр, өнгө | | | | | | | | | | |
| Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх | | | | | | | | | | |
| Түүх соёлын дурсгалт зүйлд | | | X | X | | X | | | | X |
| Археологи, палентологийн олдворт нөлөөлөх | | X | | | X | | X | | X | |
| 5. Нийгэмд үзүүлэх нөлөө | | | | | | | | | | |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх | | X | | | X | | X | X | | |
| Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх | | X | | X | | | | | X | |
| Хүн амын орлого өөрчлөгдөж | X | | | X | | | | | X | |
| Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх | | X | | X | | | | | | X |
| 6. Эднйн засаг, байгаль орчнн | | | | | | | | | | |
| Татварын орлого өөрчлөгдөх | X | | | X | | | | | X | |
| Орон нутгийн орлого нэмэгдэх | X | | | X | | | | | X | |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг | X | | | X | | | | | X | |
| Ажлын байр нэмэгдэх | X | | | X | | | | | | X |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ | X | | | X | | X | | | X | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7. Бусад нөлөөлөл | | | | | | | | | | |
| Зам харилцаа, тээврийн машин механизмын хөдөлгөөн | | X | | | | | X | | | X |
| Ахуйн бохир уснаас хөрс ба грунтын усыг бохирдох | | X | | | X | | | | X | |
| Бодисын алдагдлаар хөрс | | X | | | X | | | | X | |
| Химийн бодис, аюултай хог хаягдалтай холбогдох аюулгүй ажиллагаа, холбогдох эрх зүйг | X | | | | X | | X | X | | |
| Дүн | 11 | 12 | - | 11 | 11 | 2 | 6 | 2 | 12 | 10 |

***Шууд нөлөөлөлд*** болзошгүй нөлөөллийн 11 нь хамрагдаж байна. Энд хамгийн гол нөлөөлөл нь төслийн үйл ажиллагаа эхлэхэд тухайн талбайд өртөгдөх хөрс, ургамалд үзүүлэх нөлөөлөл байна. Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа эрхэлснээр орлого өсөх, хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх, орон нутгийн орлого болон ажлын байр нэмэгдэх зэрэгт эергээр, харин агуулахын ажлын байрны нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих нөхцөл бүрдэх, химийн бодис, аюултай хог хаягдалтай холбогдох аюулгүй ажиллагаа, холбогдох эрх зүйг зөрчих зэрэг нь сөргөөр тус тус нөлөөлөхөөр байна.***Шууд бус нөлөөлөлд*** тос тосолгооны материал, түлш бохир усны болзошгүй алдагдал нь хөрсөнд нэвчиж хөрс болон газрын доорх усыг бохирдуулан хүн амьтанд нөлөөлөх, газрын доорх усны нөөц, чанар болон хөрсний элэгдэл, бохирдол бий болох, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зөрчлүүд нь ажиллагсдын эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөлөл хамаарч байна. Мөн ядуурлыг бууруулахад эергээр шууд бус нөлөөлөхөөр байна.

***Богино хугацааны нөлөөлөлд*** ажлын байрны нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх, ахуйн болон хог хаягдлыг шаардлагын дагуу хадгалах, зайлуулах арга хэмжээг төлөвлөөгүйгээс, хогийн цэгийн битүүмжлэл, ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих зэрэг нь богино хугацааны нөлөөлөлд хамаарч байна.

*Уртхугацааны нөлөөлөлд* дээр авч үзсэн нийт 11 нь хамрагдаж байна. Гэхдээ эдгээрээс газрын доорх усны чанар, урсцын өөрчлөлт, төслийн талбай орчны хөрсний элэгдэл, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл зэрэг нь сөрөг нөлөөлөлд хамаарч байхад дэд бүтэц, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа, хүн амын орлого өөрчлөгдөх, орон нутгийн орлого нэмэгдэхэд урт хугацаанд эерэг нөлөөлөхөөр байна.

Иймээс газрын доорх усыг ямар нэг байдлаар бохирдуулахгүй байх гол арга хэмжээ нь хөрсний бохирдлоос сэргийлэх арга хэмжээг үргэлж авч хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

***Нөлөөллийн давталт:*** байгаль орчинд нөлөөлөх урт хугацааны нөлөөллүүдээс газрын доорх усны урсац ба чанарын өөрчлөлт, орчны хөрсний элэгдэл, эрчим хүчний нөөц зэрэг сөрөг нөлөөлөл болон нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллүүдээс хүн амын орлогын өөрчлөлт, орон нутгийн төсөвт оруулах орлого нэмэгдэх зэрэг эерэг нөлөөллүүд нь буцалтгүй нөлөөлөлд хамаарагдахаар байна. Харин хөрсний бохирдол, ахуйн хаягдал, зэрэг нь буцаж ажиллагсадын эрүүл мэндэд буцаж нөлөөлөх магадлалтай юм.

***Нөлөөллийн эрчим:*** нийт нөлөөллүүдээс 12 нь дунд эрчимтэй, харин татварын болон хүн амын ба орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэг эдийн засагт эерэгээр дунд зэрэг, харин асгаралт,хаягдал усаар хөрс, газрын доорх ус бохирдох, хогийн цэгийн ариутгал муугаас орчныг бохирдуулах зэрэг нь дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна.

Төслийн байршил, шийдэл, төлөвлөлттэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалтыг хийсэн. Объектын байршлын улмаас хүн ам, хүрээлэн буй орчинд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг нийт 17 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 6 зүйлд нөлөөлөлгүй байна. Нөлөөллийн зэрэглэлээр үзэхэд 4 нь бага, 5 нь дунд ба 2 нь их нөлөөлөлтэй байна. Иймд төслийн байршил, шийдэл, төлөвлөлт холбогдсон болзошгүй нөлөөлөл бага харин болон хэрэгжүүлэхтэй төслийг хэрэгжүүлэх явцад тоосжилт үүсэх, тос тосолгоо, дизель түлш асгарах болзошгүй нөлөөлөл дунд байна.

*Хүснэгт II. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт*

| *Байгаль орчны асуудлууд* | Нөлөөлөл байхгүй | Гол үр дагавар | | |
|---|---|---|---|---|
| | | Их | Дунд | Бага |
| 1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал | | | | |
| Голын гольдролыг эвдэж, өөрчлөх, эрэг эвдрэн үерийн ус тавих нөхцөл бүрдэх | X | | | |
| Төслийн байршилтай холбогдож хүн амын нүүдэл бий болох, хүн амыг зөөж байршуулах шаардлага гарах | X | | | |
| Түүх, соёлын дурсгалт газар, археологи-палентологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх | X | | | |
| Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх. | X | | | |
| Голын усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх | X | | | |
| Төслийн байршил нь төмөр зам болон бусад барилга байгууламжинд харшлах эсэх | X | | | |
| 2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал | | | | |
| Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, ус татах, хуваарилах болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой | | | X | |
| Болзошгүй осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг үер уснаас хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн | | | X | |
| Технологийн үйл ажиллагааны үед ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал болон их дуу чимээ гарах | | | X | |
| Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг | | | | X |
| 3. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал | | | | |
| Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан | | | | X |
| Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх | | | X | |
| Хөрсний эвдрэл элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа) | | X | | |
| Шуурхай хяналтын үеийн хугацаа, санхүүгийн зардал тусгагдсан | | X | | |
| Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал | | | X | |
| 4. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд) | | | | |
| Төслийн үр дүн нь биологийн төрөл зүйлд осолтой, аюулд хүргэх | | X | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжгүй болгох | | X | | |

•

• 3.2. **Төслийн гол сөрөг нөлөөлөл**

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь төслийн ашиглалтын үед тоосжилт, асгаралт үүсэх байна. Төслийн бүтээн байгуулалтын ажлын дараа нөхөн сэргээлт, орчны тохижилтын ажлыг хийсэн ч үйл ажиллагааны хяналт, хариуцлагаас хамаарч хөрсний эвдрэл, бохирдол, агаарын чанар, ажиллагсдын ажлын байрны орчин (гэрэлтүүлэг, чимээ шуугиан, чийгшилт, тоосжилт, мэргэжлээс шалтгаалах өвчлөл зэрэг) тоног төхөөрөмжийн засварын үйлчилгээнд ашиглагдах тос, тослох материалыг хөрсөнд асгаснаас үүдэх хөрсийг бохирдуулах бохирдол, бохир ус хөрсийг бохирдуулах, ахуйн хог хаягдал салхиар хийсэн орчныг бохирдуулах зэрэг асуудлууд нь сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой нөлөөллүүд байна.

Цаг агаарын хүчин зүйлсээс төслийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл

Байгалийн аюултай үзэгдлүүд болох хүчтэй салхи, шороон шуурга, бороо, үер зэрэг цаг агаарын хүчин зүйлсээс төслийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй. Манай Улсад цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 54 удаа тохиолддог байна. Сүүлийн 30 жилийг 3 арван жилд хувааж, 1 жилд тохиолдох цаг агаарын аюулт, гамшигт үзэгдлийн давтагдлыг дундажлан үзэхэд эхний 10 жилд дунджаар (1989-1998 он) 15 удаа, 2 дахь 10 жилд (1999-2008 он) 40 удаа, сүүлийн 10 жилд (2009-2018 он) 78 удаа тохиолдов. Тэдгээрээс уруйн үер 21%, салхи шуурга 21%, аянга цахилгаан 14%, нөөлөг салхи 10%-ийг эзэлж байна. Төслийн бүс нутагт 1993-2010 оны ажиглалтын мэдээнээс үзэхэд зуны улиралд нэг өдөрт (1996.08.10) 65.6 мм тунадас орсон нь тухайн жилд орсон нийт хур тунадасны 26%-ийг эзэлж байна. Энэхүү үзэгдэл нь дунджаар 15-20 жилд тохиолдох магадлалтай. Нэг хоногт ихээхэн хур тунадас орох нь өвлийн улиралд зуд болох, зуны улиралд хөрсний угаагдлыг нэмэгдүүлж үржил шимийг муутгахаас гадна байгалийн гэнэтийн аюулт үзэгдлийн нэг болох үерийн нөлөөгөөр бэрхшээл, хохирол учруулдаг.

Салхины дундаж их хурд нь жилийн 4, 5 болон 9 дүгээр сарuудад их, өвлийн сарууд болон 7, 8 дугаар сарууд бага байдаг. Салхины их хурд 1996 оны 4 дүгээр сард 28 м/с хүрч, богино хугацаанд салхины хурд огцом нэмэгдэж 40 м/с хүрч байсан.

Салхины ачаалал их болсон жилүүдэд гэр, хашаа унаж, байшингийн дээвэр цонх эвдэрч,

холбоо, цахилгааны утас унах, мал сүрэг, хүний амь эрсдэх аюул бий болдог. Иймээс цаг агаарын эдгээр хүчин зүйлсийг барилга байгууламж барих, төлөвлөхөд тооцоолоогүйгээс эд материалын хохирол учирч болзошгүй. Иймд байгалийн эдгээр эрсдэлт үзэгдлүүдээс үзүүлэх ачааллыг тооцоолон байгуулах шаардлагатай болох нь харагдаж байна.

**Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ**

Монгол улсын агаарын тухай хуулинд зааснаар “Агаарын чанар” гэж агаарын чанарын стандартад нийцэж байгаа эсэхийг илэрхийлэх агаарын физик, хими, биологийн цогц шинж чанарыг хэлдэг. Энэхүү төслийн дараах үйл ажиллагаанаас агаарын чанарт нөлөөлөл үзүүлнэ. Үүнд:

- Хөдөлгөөнт тоног төхөөрөмж, машин техникийн ашиглалтын үед тоосжилт үүсэх, түүний хөдөлгүүрээс гарах хорт хий
- Дайрга шигших үед тоосжилт үүсэх
- Тэсэлгээний цооног өрөмдөх, тэсэлгээ хийхэд тоосжилт үүсэх
- Бутлуурын төхөөрөмж дайрга бутлах үед тоосжилт үүсэх

*Хүснэгт 12. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ*

| № | Сөрөг нөлөөлөл | Нөлөөллийн төвшин | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Бага | Дун | Их | Сүйрлийн |
| 1 | Хөдөлгөөнт болон тэсэлгээний суурийн тоног төхөөрөмж, машин техник, тэслэгээний үйл ажиллагаанаас тоосжилт үүсэх | | | + | |
| 2 | Агаарын чанар өөрчлөгдөх | | + | | |
| 3 | Тоосжилтоос биологийн олон янз байдал үзүүлэх нөлөөлөл | + | | | |
| 4 | Агаар дахь тоосжилт хүн эрүүл мэндэд нөлөөлөх | | + | | |

**Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ**

Хүний үйл ажиллагааны нөлөөнөөс шалтгаалж ямар нэгэн химийн бодис болон биологийн элементээр хөрс бохирдож, хөрсөн дэх химийн бодис элементийн агууламж зөвшөөрөгдөх стандарт хэмжээнээс илүү болох үйл явцыг хөрс бохирдох гэнэ. Хөрс бохирдуулагч эх үүсвэрүүдэд янз бүрийн дэд бүтцийн байгууламжууд, техник тоног төхөөрөмжүүд, болон бусад сектороос ялгарч буй хорт нэгдлүүд, хог хаягдал, бохир ус гэх мэтийн үүсвэрүүд багтдаг.

Төслийн үйл ажиллагааны үед хөрсөн бүрхэвчинд дараах зүйлүүд нөлөөлнө.

- Төслийн нийт ашиглалтын хугацаанд 17,5 га талбайгаас үршил шимт хөрс хуулагдана. Гэхдээ тухайн төслийн талбай нь хад асгар нэм бэсрэг уулсын дунд байрлах учир дээр талбайгаас шимт хөрс хуулахад асуудал үүсэх магадлалтай. Иймд шимт хөрс хуулах боломжтой газраас давхар шимэрхэг хөрсийг хуулах шаардлагатай.
- Ашиглалт үед болон тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр орчин тойронд тоосжилт үүсэх, хөрсөн бүрхэвч элэгдэлд орно.
- Шатах, тослох материалаар хөрс тодорхой хэмжээгээр бохирдоно.
- Байгалийн өнгө, төрх байдал өөрчлөгдөнө.

*Хүснэгт 13. Хөрсөнд үзүүлэг сөрөг нөлөөллийн үнэлгээ*

| № | Сөрөг нөлөөлөл | Нөлөөллийн төвшин | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Бага | Дун | Их | Сүйрлийн |
| 1 | Машин техник, хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс талхлагдах, бохирдох | | + | | |
| 2 | Хөрсний үндсэн хэв шинж өөрчлөгдөх | | + | | |
| 3 | Хөрс органик биш бохирдуулагч бодисоор бохирдсон байдал | + | | | |
| 4 | Хөрсөн дэх хүнд металлын агууламж | + | | | |
| 5 | Хатуу хог хаягдлаас хөрс бохирдох | + | | | |

Дээрх дүнгээс харахад төслийн хэвийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх нөлөөлөл нь ихэвчлэн бага болон дунд зэрэг, харин зам талбай усалгаа хийгээгүйн улмаас тоосжилт үүсэх аюулгүй ажиллагааны дүрэм журам баримтлаагүй үед бий болох нөлөөлөл эрсдэл маш байна.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл, үнэлгээ

*Хүснэгт 14. Усанд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ*

| № | Сөрөг нөлөөлөл | Нөлөөллийн төвшин | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Бага | Дун | Их | Сүйрлийн |
| 1 | Усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм зөрчих | | | + | |
| 2 | Булгийн усанд болон зориулалтын бус газар машин | + | | | |
| 3 | Усан дах хүнд металлын агууламж /асгаралт/ | + | | | |
| 4 | Ил задгай хог хаягдал түүний улмаас усанд нөлөөлөх | + | | | |
| 5 | Шатахуун, хатуу, шингэн хог хаягдлаар газар доорх ус бохирдох | | + | | |

Хүснэгтээс харахад нийт нөлөөллийн 60% нь бага зэрэг, 20% нь дунд зэрэг, 10 нь

их гарч байгаа тул төслийн үйл ажиллагаанаас газар доорх усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл багаас дунд зэрэг байна.

Төслийн талбайд байгалийн гамшигт үзэгдэл, гэнэтийн осол, ажилчдын санамсар болгоомжгүй үйлдлээс шалтгаалан түлш, тос тосолгоо асгарсан дараах тохиолдлуудад хөрсийг бохирдуулж (тухайн бохирдлыг саармагжуулах, бууруулах арга хэмжээ аваагүй тохиолдолд) улмаар хур бороо орсон үед үерийн усаар дамжин Сухантын голыг бохирдуулж болзошгүй. Үүнд: Барилгажилтын үе шатанд: Барилга, байгууламжуудыг барих үед хэрэглэх барилгын материал (цемент, будаг, лак) асгарсан тохиолдолд;

Тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөс ШТМ асгарсан тохиолдолд хөрсийг бохирдуулж, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын усыг бохирдуулж болзошгүй.

Ашиглалтын үе шатанд:

- ШТС, ШТМ-ын агуулах, засварын газар, машины зогсоол, тээврийн хэрэгслүүдээс ШТМ асгарсан тохиолдолд;

Ургамлан бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр талбай орчмын өвслөг ургамал дараах нөлөөллүүд үүснэ. Барилгын үйл ажиллагааны үед дараах хүчин зүйлс ургамлан бүрхэвчинд нөлөө үзүүлнэ.

Үүнд:

- Төслийн барилгын явцад хуулагдах талбайгаар хөрстэй хамт ургамалжилт үгүй болно.
  - Техникийн нөлөөгөөр үүсэх тоосжилт нь ургамлын бодисын солилцооны эрчмийг бууруулах, улмаар ургамлын морфологид дараах өөрчлөлтүүд гарч болзошгүй. Үүнд:
    - Ургамлын зүйлүүдийн амсарын эс бөглөрөх, навч хорчийж хатах, хагдрах,
    - Фотосинтезийн эрчим буурч ургамлын өсөлт удаашрах, o Дээрх бүгдээс шалтгаалан ургамлын фотосинтезийн идэвхитэй хэсэг (газар дээрх)-ийн хэмжээ багасаж, улмаар бүс нутгийн ургамлын биомассын хэмжээ буурах зэрэг болно.

*Хүснэгт 15. Ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөө*

| № | Сөрөг нөлөөлөл | Нөлөөллийн төвшин | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Бага | Дун | Их | Сүйрлийн |
| 1 | Машин техник, хүний үйл ажиллагаагаар ургамлан бүрхэвч талхлагдах, устаж үгүй болох | | + | | |
| 2 | Барилгажилт төслийн ашиглалтын нөлөөгөөр ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл | | | + | |
| 3 | Тоосжилтын үзүүлэх нөлөө | + | | | |

**Дуу шуугианы нөлөөлөл**

Ашиглалтын үе шатанд: Үйл ажиллагааны үед ашиглагдах гол тоног төхөөрөмж нь уурхайн бусад үйл ажиллагаанд ашиглагдах хүнд даацын тээврийн хэрэгслүүдээс бага дуу чимээтэй болно...

Тээврийн болон бутлуурын хэрэгслүүд нэгэн зэрэг ажиллахад нийлбэр дуу шуугиан 121.73 дБА, суудлын болон хөнгөн тээврийн хэрэгслүүд нэгэн зэрэг ажиллах үед гарах дуу шуугианы түвшин 78.9 дБА, эдгээр утгууд нь стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 18.9-61.73 дБА-аар бага буюу хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байна.

# 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Бид Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн, уурхайн ашиглалтын үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө зэргийг үндэслэж тухайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулլаа.

Чухамжараглан ХХК нь “Барилгын чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төслийн тухайн жилийн байгаль орчны менежтентийн төлөвлгөөний гол зорилт хуулийн хүрээнд байгаль орчны өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн тус төслийн тогтвортой үйл ажиллагаа явуулахад оршино

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ нь SGMV-00009 тоот ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбайд хамаарна.

# 5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Чухамжаргалан” ХХК -ийн Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших SGMV-00009  тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Хөвийн барилгын чулууны ордыг ил аргаар ашиглах” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн А-618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” зэрэгт тулгуурлан боловсруулсан болно

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардалд 23 600 000(Хорин гурван сая зургаан зуун мянга) төгрөг төсөвлөгдсөн.

| Д/д | Бүрэлдэхүүн | 2025 он сая.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 7.6 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 5.6 |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 2.0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 5 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | Хийгдсэн |
| 6 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2.0 |
| 7 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1.2 |
| 8 | Удирдлага зохион байгуулалт | - |
| 9 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 0.2 |
|  | **Тухайн жилийн зардал, сая төг** | **23.6** |

# 5.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

**Хүснэгт 32. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан**

| Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл | Байгалийн бүрдэл хэсэг | Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | Хэрэгжүүлэх цар хүрээ |
|---|---|---|---|---|
| 1.1 | Агаарын чанар | Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох | Тоос дарах төхөөрөмж буюу мананжуулагч байрлуулах, орлуулах бууруулах арга хэмжээ авах | Хайрганы 2 үйлдвэрийн дээд хэсэгт удирдлагын өрөөны хажууд 1 тонны сав байрлуулж, бороужуулагч төхөөрөмж байршуулан тоосжилтыг бууруулахаар төлөвлөсөн. Одоогоор бороожуулах системийг хийж гүйцэтгэх ажил хийгдаж байна. |
| 1.2 | Гүний ус | Шатах тослох материалыг алдснаар хөрсийг бохирдуулснаас газрын доорхи ус бохирдох | АХХ цэг сайжруулах | Хаягдал бүхий талбайг цэвэрлэж, эмхэлж ангилалт хийсэн.<br>Тос, шатахууны сав, барилгын хаягдлыг тусад нь ялгаж, зориулалтын саванд хийж хадгалсан.<br>Цэвэр, тосны болон аюултай хаягдлын савыг өнгөөр ялган тэмдэглэж, тус тусад нь байрлуулсан. |
| 1.3 | Хөрс | Шатах тослох материал асгарах, гэнэтийн болзошгүй аваар ослоос үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах | ШТС олголтын талбайд хөрсөн бүрхэвчийг хамгаалах | Хаягдал бүхий талбайг цэвэрлэж, эмхэлж ангилалт хийсэн.<br>Тос, шатахууны сав, барилгын хаягдлыг тусад нь ялгаж, зориулалтын саванд хийж хадгалсан.<br>Цэвэр, тосны болон аюултай хаягдлын савыг өнгөөр ялган тэмдэглэж, тус тусад нь байрлуулсан. |
| 1.4 | Ургамлан нөмрөг | Уурхайн үйл ажиллагаанаас ургамалан бүрхэвч доройтох | Жил бүр ургамлын судалгаа мониторинг явуулах, нөхөн сэргээлт хийхэд тохиромж үр түүх | Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор жил бүр ургамлын судалгаа болон мониторингийн ажлыг тогтмол зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд тухайн орчны хөрсний бүтэц, чийгийн хэмжээ, ургамлын ургалтын байдалд судалгаа хийж, нөхөн сэргээлт хийхэд хамгийн тохиромжтой ургамлын төрөл, үрийг сонгох ажил хийгддэг. |
| 1.5 | Амьтны аймаг | Нөхөн сэргээлтийг журмын дагуу хийгээгүйгээс амьдрах орчин доройтох | Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт хийж байх | Төслийн хүрээнд ажиллаж байгаа нийт ажилчдад дараах сургалтыг орсон.<br>• хог хаягдлын менежмент,<br>• Асгаралтаас урьдчилан сэргийлэх сургалт<br>• Зэрлэг ан амьтны хууль бус үйлдлийн эсрэг үйл ажиллагаа<br>• Түүх соёлын өвийг хамгаалах сургалт орсон. |
| 1.6 | | Уурхайн ажилчид хууль бусаар амьтан агнах үйлдэл гаргах | Ажилчдын тосгонд галт зэвсэг болон бусад зэвсэг хэрэглэхийг хориглох | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.7 | | ЦДАШ-ыг шувуу мөргөх, тогонд цохиулах | Шувууны нислэгийн чиглэл өөрчлөгч /үргээгч/ болон шувууны суулт /үүр/ суурилуулах | |
| **Нийт** | | | | |

***Тоос дарах төхөөрөмж буюу мананжуулагч байрлуулах, орлуулах бууруулах арга хэмжээ авах***

## 1. Ерөнхий зорилго

Агаарын чанарыг сайжруулах, ажилчдын хөдөлмөрийн нөхцлийг хамгаалах, ойр орчмын экосистемд сөрөг нөлөөлөл үзүүлэхээс сэргийлэх зорилгоор тоосжилтыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

---

## 2. Тоосжилтын үүсгэх гол эх үүсвэрүүд

| *№* | *Эх үүсвэр* | *Үүсэх шалтгаан* | *Нөлөөлөл* |
|---|---|---|---|
| 1 | Түүхий материалын овоолго | Салхинд хийсэх, ачих, буулгах | Агаар бохирдуулах, харагдах орчныг муутгах |
| 2 | Бутлуур, шигшүүр | Бутлалт, шигшилтийн явцад нарийн ширхэгт тоос үүсэх | Агаар бохирдуулах, ажилчдын эрүүл мэндэд сөрөг |
| 3 | Тээврийн зам | Хуурай, тоосонцортой шороон замаар тээвэрлэх | Тоос шороо агаарт дэгдээх |
| 4 | Ачилт, буулгалт | Материалыг механикаар зөөх | Орон нутгийн орчны бохирдол |

---

## 3. Тоосжилт бууруулах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө

### 3.1. Техникийн арга хэмжээ

1. **Усалгааны систем суурилуулах**
   - Усалгааны систем хийх /бороожуулагч/ 2025
   - Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулсан
   - Ордын гидрогеологийн судалгааны ажил хийлгэх 2026 он
   - Шүүрлийн ус ашиглах 2026 он
   - Бутлуур, шигшүүрийн орчим болон тээврийн замд тогтмол усалгааны систем ажиллуулах.

- 20–30 минут тутамд автоматаар ус шүрших системийг байрлуулах.
- Усалгаанд хэрэглэгдэх ус нь үйлдвэрийн хаягдал усыг дахин ашиглах боломжтой байх.

2. **Тоос дарахад**
    - Бороожуулагч ашиглаж усалгааг хийх.
3. **Талбайг хашаажуулах ба салхинаас хамгаалах байгууламж барих**
    - 1-2 м өндөртэй шороон далан эсвэл төмөр торон хашаа барьж, салхины хурдыг сааруулах
4. **Ногоон зурвас байгуулах**
    - Үйлдвэрийн гадна хэсэгт 10–15 м өргөнтэй мод бут бүхий ногоон зурвас бий болгож салхины чиглэлд байрлуулах. 2026- 2028 онд

---

### 6. 3.2. Зохион байгуулалтын арга хэмжээ

1. Тоосжилт үүсэх эрсдэлтэй үед (хуурай, салхитай үед) үйлдвэрлэлийн ачааллыг багасгах.
2. Ажилчдад хамгаалах хэрэгсэл (маск, нүдний шил) олгох.
3. Тоосжилтын түвшинг сар бүр хэмжих, хяналт тавих. Тоосжилт хэмжих багаж худалдан авах
4. Зам талбайг өдөр бүр услах, шалгах үүрэгтэй ажилтан томилох.

---

## 4. Хэрэгжилтийн хугацаа ба хяналт

| *Үе шат* | *Хугацаа* | *Хариуцах этгээд* | *Хяналтын хэлбэр* |
|---|---|---|---|
| Усалгааны систем суурилуулах | 2025.XI сар | Үйлдвэрийн инженер | Талбайн үзлэг |
| Хашаа, ногоон зурвас байгуулах | 2026.I–V сар | Байгаль орчны мэргэжилтэн | Сар бүрийн тайлан |
| Ус ашиглалттай холбоотой бичиг | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Тоос дарах бодис ашиглах | Тогтмол | Үйлдвэрийн дарга | Бүртгэлийн хуудас |

## 5. Хүлээгдэх үр дүн

- Тоосжилтын түвшин 50–70% буурах
- Агаарын чанар сайжрах
- Ажилчдын эрүүл мэндийн эрсдэл буурах
- Орон нутгийн орчны бохирдол багасах




ЧУХАМ ЖАРГАЛАН

Батлав: Үйл ажиллагаа хариуцсан захирал ............................. Г.Гантулга

**“Чухамжаргалан” Хөв хайрганы үйлдвэрийн тоосжилт бууруулах төлөвлөгөө**

Боловсруулсан: Д.Болортуяа

Бид шаардлагатай үед талбайн тоосжилтыг бууруулахад усалгааны машин ашиглаж бууруулж байна.

Хайрганы 2 үйлдвэрийн дээд хэсэгт удирдлагын өрөөны хажууд 1 тонны сав байрлуулж, боруужуулагч төхөөрөмж байршуулан тоосжилтыг бууруулахаар төлөвлөсөн. Одоогоор бороожуулах системийг хийж гүйцэтгэх ажил хийгдаж байна.





***Ахх цэг сайжруулах***

*АХХ ЦЭГ САЙЖРУУЛАЛТЫН ТАЙЛАН*

1. Зорилго
Аж ахуйн хог хаягдлын (АХХ) цэгийн нөхцөл байдлыг сайжруулж, хаягдлын ангилалт, хадгалалт, түр хадгалах орчны стандартыг хангах, байгаль орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилготой.

---

2. Байдал (өмнө нь)
АХХ цэгт төрөл бүрийн хаягдал эмх цэгцгүй, ангилагдаагүй байдалтай, сав баглаа боодол болон тос, шатахууны үлдэгдэлтэй савнууд ил задгай байршсан байсан. Энэ нь орчны бохирдол үүсгэх, осол, галын эрсдэлтэй нөхцөл байдал байв.
*(Зураг – “өмнө нь”)*

---

3. Хийсэн ажлууд
Хаягдал бүхий талбайг цэвэрлэж, эмхэлж ангилалт хийсэн.
Тос, шатахууны сав, барилгын хаягдлыг тусад нь ялгаж, зориулалтын саванд хийж хадгалсан.
Цэвэр, тосны болон аюултай хаягдлын савыг өнгөөр ялган тэмдэглэж, тус тусад нь байрлуулсан.
Цэгийг хүрээлэн хязгаарлалт хийж, орчны цэвэр байдлыг хангаж сайжруулсан.
*(Зураг – “дараа нь”)*

---

4. Үр дүн
Сайжруулалтын дараа АХХ цэг нь стандартын дагуу ангилагдсан, цэвэр орчин бүрдсэн, хог хаягдлын удирдлага сайжирсан.
Байгаль орчны бохирдлын эрсдэл буурсан
Ажилчдын аюулгүй ажиллагаа сайжирсан
Хаягдлыг дахин ашиглах, зайлуулах нөхцөл бүрдсэн

---

5. Дүгнэлт
   АХХ цэгийн сайжруулалт нь байгууллагын байгаль орчны хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд чухал алхам болсон. Цаашид хог хаягдлын менежментийг тогтмол хянаж, тэмдэглэгээ, бүртгэл

хөтлөн ажиллах шаардлагатай.Ангилан ялгалтын цэгийг хашаажуулах, тэмдэг тэмдэглэгээ хийх






өмнө нь

дараа нь





***Түлш олголтын талбайд хөрсөн бүрхэвчийг хамгаалах***

**Түлш олголтын талбайд херсийн бүрхэвчийг хамгаалах ажлын хэрэгжилтийн тухай тайлан**

**1. Ажлын зорилго**

Түлш олголтын талбайд газрын хөрсийг бохирдохоос урьдчилан сэргийлэх, газрын эвдрэл доройтлыг багасгах, байгаль орчны стандарт шаардлагад нийцсэн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор хуучин талбайг шинэчлэн тохижуулах ажлыг хэрэгжүүлэв.

**2. Хэрэгжүүлсэн арга хэмжээ**

- Хуучин түлш олголтын талбайг нүүлгэн шилжүүлж, хөрсний хамгаалалтын ажил гүйцэтгэж, Бохир хөрс саарсагжуулах талбайн үлдсэн мүмбохирдол үүсэхээс сэргийлэх зорилгоор талбайн гадаргууг тэгшилж, хайрга дэвсэж бэхжүүлсэн.
- Ирэх 2026 онд тухайн талбайд бетон хучилт бүхий шинэчлэл хийхээр төлөвлөсөн бөгөөд үүнтэй холбогдуулан инженерийн бэлтгэл болон талбайн тэгшилгээний ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.

2. **Үр дүн**

   Хөрсний бохирдол, шүүрэл үүсэх эрсдэл буурч, талбайн ашиглалтын аюулгүй байдал сайжирсан. Ирээдүйд бетон хучилт хийгдсэнээр байгаль орчны хамгааллын шаардлага бүрэн хангагдаж, түлш хадгалах болон олгох үйл ажиллагааг стандартын дагуу явуулах нөхцөл бүрдэнэ.





### *Жил бүр ургамлын судалгаа мониторинг явуулах, нөхөн сэргээлт хийхэд тохиромж үр түүх*

Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор жил бүр ургамлын судалгаа болон мониторингийн ажлыг тогтмол зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд тухайн орчны хөрсний бүтэц, чийгийн хэмжээ, ургамлын ургалтын байдалд судалгаа хийж, нөхөн сэргээлт хийхэд хамгийн тохиромжтой ургамлын төрөл, үрийг сонгох ажил хийгддэг.

2025 онд нутгийн ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, ургуулах ажлыг өөрийн байгууллагын хашаанд хийж хэрэгжүүллээ. Энэ хүрээнд **Жигд, Шар хуайс зэрэг нутгийн байгальд тэсвэртэй модлог ургамлын үрийг цуглуулж, туршилтын аргаар үрслүүлэн ургуулах** ажил зохион байгуулагдсан.

Цаашид нөхөн сэргээлтийн ажлын чанарыг сайжруулах үүднээс тухайн ургамлын ургалтын явцыг жил бүр хянан, амьдрах чадвар, хөрсний чийгшил, ургах нөхцөлийн мэдээллийг бүртгэлжүүлж, дараагийн нөхөн сэргээлтийн төлөвлөлтөд ашиглахаар зорьж байна.

Түүнчлэн нөхөн сэргээлтийн талбайд ургамал тарьж, арчилгаа усалгаа хийж буй ажилчид хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатайгаар хамгаалах хувцас, хэрэглэлтэй ажиллаж байна. Үрслэг болон таримлын ажлыг байгаль орчны мэргэжилтэн байнга хянан удирдаж, нөхөн сэргээлтийн үр дүнг тогтмол үнэлж байна.









**Ургамлын мониторинг**

Төслийн талбайд 2 бичиглэл хийхэд үндсэн 2 бүлгэмд хуваагдаж байна. Үүнд:

- Тэсэг – боролзой-шавагт, холимог сөөгт
- Хотирт-холимог сөөгт бүлгэмд байна.

Хад чулуутай жижиг уулсаараа Тэсэг – боролзой-шавагт, холимог сөөгт, түүний хөндийгөөр шарилж – шаваг- холимог сөөгт бүлгэмдэлтэй. Тус талбай нь Гурвантэс сумын өмнө байрлах нам уулын хажуу, хөндийгөөр тархах бөгөөд Тэсэг – боролзой – шавагт, холимог сөөгт бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 5%, 23 зүйлийн ургамал ургасан, 1 м2-д 3-5 орчим зүйл тааралдаж бүртгэгдсэн, ургац 0,6 ц/га байсан. Сөөг 50 – 80 см өндөртэй, өвслөг ургамал 5 см өндөртэй. Ус урсах хэсгээр шарилжит бүлгэмдэл үүссэн. Зонхилогч ургамлын хувьд үетнээс сайрын хялгана, алаг өвснөөс таана, монгол сүүт өвс, зэлэн зангуу, сөөгнөөс Монгол бүйлс, Монгол догар, цагаалин харгана, орог тэсэг, шар модот хотир ургана. Бэлчээрийн талхагдал бага.





*Бичиглэл -1*

| Ургамлын зүйлийн бүрдэл | | | | | |
|---|---|---|---|---|---|
| № | Ургамлын латин нэр | Ургамлын монгол нэр | Бүрхэц, % | ангилаа | Ашигт ургамал |
| 1 | *Ajiana trifida* | *Гурвалсан салбант бороолз* | 1 | бэлчээр | |
| 2 | *Allium mongolicum* | *Хөмүүл* | | бэлчээр | элбэг |
| 3 | *Allium polyrrhizum* | *Таана* | 1 | бэлчээр | элбэг |
| 4 | *Amygdalus pedunculata* | Бариулт бүйлээс | 1 | бэлчээр | элбэг |
| 5 | *Anabasis brevifolia* | *Ахар навчит баглуур* | | бэлчээр | элбэг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | *Artemisia globosoides* | Шардуу шарилж | | бэлчээр | |
| 7 | *Caryophyteris mongolica* | *Монгол догар* | | бэлчээр | элбэг |
| 8 | *Dracochephallium foetidium* | *Үмхий шимтэглээ* | 1 | бэлчээр | элбэг |
| 9 | *Euphorbia mongolicum* | *Монгол сүүт өвс* | | бэлчээр | элбэг |
| 10 | *Karshinikovia ceratoides* | *Орог тэсэг* | | бэлчээр | |
| 11 | *Stipa glaerosa* | *Сайрын хялгана* | 1 | дүүргэгч | элбэг |
| 12 | *Tribulus terretris* | *Зэлэн зангуу* | | бэлчээр | элбэг |
| 13 | *Zygophyllium xanthoxylon* | *Хотир* | | бэлчээр | элбэг |
| 14 | *Caragana brachypoda* Pojark.- | Хойрог харгана | | бэлчээр | элбэг |
| 15 | *Limonium tenellum* | *Нарийн бэрмэг* | - | бэлчээр | элбэг |
| 16 | *Peganum harmala* | *Эгэл өмхий өвс* | | бэлчээр | |
| 17 | *Asparagus gobicus* | *Говийн хэрээннүд* | * | бэлчээр | элбэг |
| 18 | *Oxytropis aciphylla* | *Өргөст ортууз* | | Бэлчээр | ховор |
| 19 | *Convolvulus ammonii* | *Аммоний сэдэргэнэ* | 1 | бэлчээр | элбэг |
| 20 | *Ephedra sinica* | *Нангиад зээргэнэ* | | бэлчээр | элбэг |
| 21 | *Asterothamnus poliifolius* | *Навчирхаг лавай* | | бэлчээр | ховор |
| 22 | *Scrozonera capito* | Данхар хависгана | | бэлчээр | элбэг |
| 23 | *Incarvilla Potaninii* | Потанины улаан тулам | | бэлчээр | Нэн ховор |

2.Хотирт –холимог сөөгт (243/ H-V-3-1)



*Төслийн талбайн доторх ургамал бичиглэл №2*

*Зураг 1.*

Тус талбай нь замын трасс дагуу тэгш хөндийгөөр тархах бөгөөд цөлийн хотирт бүлгэмдэлтэй, тусгагийн бүрхэц 20%, 10 зүйлийн ургамал (бичиглэл-2) бүртгэгдсэн,

ургац 0,4 ц/га байсан. Өвслөг ургамлын 5 см өндөртэй, сөөг 60 хүртэл см өндөртэй байсан. Зонхилогч ургамлын хувьд үетнээс сайрын хялгана, алаг өвснөөс хөмүүл, таана,алтайн сонгоолж, ширэг улалж, сөөгнөөс регелийн будраа, улаан бударгана, цагаан харгана, шар хотир ургана. Бэлчээрийн талхагдал бага. Гандуу байсан.

*Бичиглэл -2*

| Ургамлын зүйлийн бүрдэл | | | | | |
|---|---|---|---|---|---|
| № | Ургамлын латин нэр | Ургамлын монгол нэр | Бүрхэц, % | ангилаа | Ашигт ургамал |
| 1 | *Caragana stenophylla* | *Нарийн навчит харгана* | 2 | бэлчээр | элбэг |
| 2 | *Reamurea songorica* | *Улааг бударгана* | 1 | бэлчээр | |
| 3 | *Carex duriuscula* | *Ширэг улалж* | * | бэлчээр | элбэг |
| 4 | *Stipa glaerosa* | *Сайрын хялгана* | 1 | бэлчээр | элбэг |
| 5 | *Allium mongolicum* | *Хөмүүл* | 3 | бэлчээр | элбэг |
| 6 | *Allium polyrrhizum* | *Таана* | 1 | бэлчээр | элбэг |
| 7 | *Bassia dasyphylla* | *Манан хамхаг* | * | дүүргэгч | элбэг |
| 8 | *Heteropappus altaicus* | *Алтайн согсоолж* | 1 | бэлчээр | элбэг |
| 9 | *Sympegma regellii* | *Регелийн будраа, шар мод* | 3ш | бэлчээр | |
| 10 | *Zygophyllium xanthoxylon* | *Шар хотир* | 8ш | бэлчээр | элбэг |



### *Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт хийж байх*

Төслийн хүрээнд ажиллаж байгаа нийт ажилчдад дараах сургалтыг орсон.

- хог хаягдлын менежмент,
- Асгаралтаас урьдчилан сэргийлэх сургалт
- Зэрлэг ан амьтны хууль бус үйлдлийн эсрэг үйл ажиллагаа
- Түүх соёлын өвийг хамгаалах сургалт орсон.

Хориотой ан амьтан агнасан, түүний эд эрхтэнг худалдан борлуулсан иргэнд хуульд заасан зүйл залтын дагуу хариуцлага хүлээлгэдэг. Санаатай болон санамсаргүй байдлаар хориотой ан амьтан агнасан, түүний эд эрхтнийг худалдан борлуулсан иргэд хүлээлгэх хариуцлага ,иргэд хуулийн мэдлэг багатайгаасаа болоод хэн нэгний ятгалгаар бүлэглэн ан агнасан, түүний эд эрхтнийг худалдан борлуулах гэмт хэрэгт холбогдож байгаа талаар ухуулсан сурталчилах, түүнчлэн жилээс жилд хулгайн анчдын гарт өртөж тоо толгой нь улам ховордож, устах аюулд өртөөд байгаа ан амьтдыг хамгаалахын тулд хулгайн анчдын талаарх мэдээллийг харьяа сумынхаа экологийн албаны мэргэжилтэн, цагдаагийн байгууллагад өгөх боломжтой талаар сургалт орж таниулах боршур байршуулан ажиллалаа.





Байгаль орчны тухай сургалт:

- Сургалтын сэдэв: Хог хаягдлын менежмент
- Сургалтын сэдэв: Асгаралтаас урьдчилан сэргийлэх сургалт
- Сургалтын сэдэв: хог хаягдлын менежментийн сургалт
- Сургалтын сэдэв: Зэрлэг амьтны хууль бус үйлдлийн эсрэг ажилчдад сургалт
- Сургалтын сэдэв: Түүх соёлын өвийг хамгаалах сургалт

Танилцуулсан: Байгаль орчны мэргэжилтэн Гарын үсэг: Д Болортуяа [illegible]

Эхлэх цаг: 11:00 Дуусах цаг: 11:40 Огноо: 2024.05.02

| № | Овог Нэр | Албан тушаал<br>Хэсэг | Огноо | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | Нярав | 2024.09.01 | [illegible] |
| 2 | [illegible] | Оператор | 2024.09.01 | [illegible] |
| 3 | [illegible] | оператор | 2024.09.01 | [illegible] |
| 4 | [illegible] | Оператор | 2024.09.01 | [illegible] |
| 5 | [illegible] | Ахлах оператор | 2024-09-01 | [illegible] |
| 6 | [illegible] | оператор | 2024.9.01 | [illegible] |
| 7 | [illegible] | [illegible] Оператор | 2024-09-01 | [illegible] |
| 8 | [illegible] | оператор | 2024.09.01 | [illegible] |
| 9 | [illegible] | [illegible] | 2024.09.01 | [illegible] |
| 10 | [illegible] | [illegible] | 2024.9.01. | [illegible] |
| 11 | | | | |
| 12 | | | | |
| 13 | | | | |
| 14 | | | | |






***Шувууны нислэгийн чиглэл өөрчлөгч /үргээгч/ болон шувууны суулт /үүр/ суурилуулах***

**Шувууны нислэгийн чиглэл өөрчлөх /үргэх/ болон шувууны суурь /үүр/ суурилуулах арга хэмжээний тайлан**

Ерөнхий мэдээлэл

Нарийвчилсан үнэлгээний зөвлөмжийн дагуу нийт 3 ширхэг шувууны үүр хийж, байгальд тохиромжтой байршилд суурилуулсан. Энэхүү арга хэмжээний зорилго нь шувуудын амьдрах орчныг дэмжих, үйлдвэрийн нөлөөллөөс үүдэх орчны өөрчлөлтийг багасгах, амьтдын нутагшилт, үржилд ээрэг нөхцөл бүрдүүлэхэд оршино.

---

Шувууны үүрний байршил ба онцлог

Шувууны үүрийг тухайн бүс нутгийн амьтны зүйлийн онцлог, газар нутгийн нөхцөлд нийцүүлэн байршуулсан.

Ерөнхийдөө үүрийг газрын дээрх хэсэг, хадтай бүсийн ойролцоо байршуулсан нь шувуудын аюулгүй, тогтвортой нутагших нөхцөлийг бүрдүүлж байна.

Үүр хийхэд ашигласан материал нь байгальд ээлтэй, дулаан хадгалах чадвартай модон бүтэцтэй бөгөөд үүр бүрийг 2–3 шувуу амьдрах боломжтой байдлаар төлөвлөсөн. Үүрний байрлал нь ангаахай өсөхөд тохиромжтой, нарны илчлэг, агаарын урсгал, аюулгүй байдлын шаардлагыг хангаж байна.

---

Үүр барих хугацаа ба улирлын тохиргоо

Шувууны үүрийг барих хамгийн тохиромжтой улирал нь хаврын эхэн сард тул ажлыг тухайн хугацаанд бүрэн гүйцэтгэсэн.

---

Хийсэн ажлын дүн

Хэрэгжүүлсэн ажил нь шувуудын амьдрах орчныг дэмжиж, байгаль орчны хамгааллын зорилтыг хангахад чухал ач холбогдолтой болсон.

Үүрийг тогтмол шалгаж, шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээж засвар хийх, шувуудын нутагшилт болон үржилд ажиглалт хийхийг ирэх жилээс зохион байгуулна.

---

Дүгнэлт

Энэхүү арга хэмжээ нь шувуудын байгалийн амьдрах орчныг хадгалах, нөхөн сэргээх бодит үр нөлөөтэй ажил боллоо.

**Экологийн ач холбогдол:**

- Уул уурхайн болон бусад хүний үйл ажиллагааны нөлөөгөөр устаж, сарнисан шувуудын амьдрах орчныг нөхөн сэргээхэд хувь нэмэр оруулна.
- Шувууд газар нутгийн **шавьж, мэрэгч амьтдын тоог тэнцвэржүүлэхэд** чухал үүрэгтэй тул экосистемийн тэнцвэрийг хадгалах ач холбогдолтой.

**Байгаль хамгааллын бодит үр дүн:**

- Үүрэнд шувуу суурьшсан байдал (зурагт байгаа шиг) нь арга хэмжээ **үр дүнтэй хэрэгжсэн** гэсэн нотолгоо болдог.
- Энэ нь байгууллагын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд туссан **биотехникийн ажлын үр дүнг баталгаажуулж буй баримт** болно.

**Тайланд тусгах хэлбэрийн жишээ:**

“2025 онд хийгдсэн биотехникийн ажлын хүрээнд шувууны үүрийг байршуулж, байгальд нутагшуулах орчныг бүрдүүлснээр тухайн бүсэд шувууд суурьшин амьдрах нөхцөл бий болсон. Энэ нь экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хадгалах ач холбогдолтой ажил боллоо.”

---

Фото баримт

*(Доорх зургууд нь суурилуулсан шувууны үүр болон талбайн байршлын гэрэл зураг юм.)*









## 5.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Техникийн нөхөн сэргээлт хийх | Гүйцэтгэх ажил | 2025 онд | |
|---|---|---|---|
| Хамгаалалтын далан байгуулах | Газрын нурал, элэгдлээс хамгаалах далан, хашлага хийх, | 3.600.000 | 6,576,667 |
| Экосистемийн нөхөн сэргээлт | Төсөлд өртсөн газар нутагт ургамалжилт, хөрс, амьдрах орчныг сэргээх ажлын хүрээнд төслийн хүрээнд ойр байдаг ХӨВ булгийг түшиглэн урсацыг сайжруулан, ам амьтан услах уст цэг байгуулах | 2.000.000 | 4,171,000 |
| | Нийт мян.төг | 5.600.0 | 10,747,667 |

***Газрын нурал, элэгдлээс хамгаалах далан, хашлага хийх***

Олон жилийн өмнө ашиглалтын явцад эвдрэлд орсон төслийн талбайн хажуу хэсгийн газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж байна. Энэхүү ажлын зорилго нь газрын гадаргын хэлбэржүүлэлт, нуранги, элэгдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, цаашид биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлтгэх явдал юм.

2025 онд тус талбайд нийт 5261 м² хэмжээтэй хуучин ухашид техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүллээ:

- ✓ Ухаш болон эвдэрсэн хэсгийн ирмэг, хажуу налууг тэгшилж, тогтвортой хэлбэрт оруулсан.
- ✓ Нуранги үүсэх магадлалтай хэсгүүдэд чулуу, хаягдал хөрсөөр далан, хашлага хийж тогтворжуулсан.
- ✓ Газрын дүүргэлтийн ажлыг эхлүүлж, суурь давхаргыг барьж байгуулсан.

Нүүр хэсэгт түр овоолсон хөрсийг ашиглан тэгшилгээ хийж, биологийн нөхөн сэргээлт хийх бэлтгэлийг хангаж байна.

2025 оны 10 сарын 20ны байдлаар талбайн дүүргэлтийн ажил бүрэн дуусгасан. Хөрсний тогтворжилт хангагдсаны дараа 2026 оны ажлын төлөвлөгөөнд биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.

Биологийн нөхөн сэргээлтийн хүрээнд дараах ажлуудыг төлөвлөж байна:

Дүүргэсэн талбайд өнгөн хөрсөөр хучилт хийх;

Байгальд ургадаг, тухайн бүсийн уур амьсгалд тохирсон нутгийн өвс, бут сөөг тарих;

Тарьц ургамлын ургалт, хөрсний чийгшлийг тогтмол хянах, арчилгаа хийх.

Дүгнэлт:

2025 онд хуучин эвдэрсэн 5261 м² талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил амжилттай хийгдэж, газар хэлбэржүүлэлт, тогтворжуулалтын ажил хийгдсэн. Тус талбайн техникийн нөхөн сэргээлтийн ажил бүрэн дуусаж 2026 онд биологийн нөхөн сэргээлт хийх бөгөөд уг ажил нь байгаль орчныг сэргээх, газрын элэгдэл, нурангаас хамгаалахад чухал ач олбогдолтой болно.

| Нийт талбай (м2) | Дүүргэлтийн гүн | Нийт эзлэхүүн (м3) | Рейсийн тоо (24 м³/тэвш) | Нийт өртөг (20.000 ₮/м³) |
|---|---|---|---|---|
| 5261 | 1.5 м | 7,892 | 329 | **6,576,667** |













***Төсөлд өртсөн газар нутагт ургамалжилт, хөрс, амьдрах орчныг сэргээх ажлын хүрээнд төслийн хүрээнд ойр байдаг хөв булгийг түшиглэн урсацыг сайжруулан, ам амьтан услах уст цэг байгуулах***

**Төслийн хүрээнд ойр орчны экосистемийг сэргээх, амьтны усан хангамжийг сайжруулах арга хэмжээний хэрэгжилтийн тухай тайлан**

**1. Ерөнхий мэдээлэл**

Төслийн нөлөөллийн бүсэд орших газар нутгийн ургамалжилт, хөрс, амьдрах орчныг хамгаалах зорилгоор байгаль орчны нөхөн сэргээлтийн хүрээнд ойролцоох Хөв булаг дээр тулгуурлан хийхээр төлөвлөсөн ч ундрага муудаж ус гараагүй тул Тос Тосон бумбатай хамтран төлөвлөгөөнөөс өөр байршилд худаг цэг дээр тулгуурлан зэрлэг амьтдад зориулсан услах цэг байгуулах ажлыг эхлүүлсэн.

**2. Хэрэгжүүлсэн арга хэмжээ**

- “Тост тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаатай” хамтран, усан хангамжийн нөхцөлийг сайжруулах зорилгоор **худаг, усан цэгийг шинэчлэн хөв байгуулах** ажлыг эхлүүлсэн.
- Энэхүү ажлын хүрээнд газар дээр суурилуулсан хөв, ус шахуурга, нарны зайн хураагуур, ус хураах сав зэрэг тоног төхөөрөмжийг суурилуулахаар төлөвлөсөн.

**3. Санхүүжилт**

Ус хангамжийн байгууламжийг байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах, суурилуулах ажилд нийт **4,171,000 төгрөгийн зардал** гаргасан.

Зардлын баримт болон “Тост тосон бумбын нурууны хамгаалалтын захиргаа”-аас гаргасан техникийн хүлээлцсэн акт, зургийн хавсралттай.

**4. Хууль эрх зүйн үндэслэл**

Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох заалтын дагуу, уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн бүсэд нөхөн сэргээлт, байгаль орчны сайжруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ биелүүлсэн болно.

**5. Дүгнэлт**

Төслийн нөлөөллийн бүсэд байгаль орчны нөхөн сэргээлтийн хүрээнд усан хангамжийг сайжруулах, амьтдын услах нөхцөлийг бүрдүүлэх ажил бүрэн хэрэгжиж, байгаль хамгааллын байгууллагын хяналт шалгалтаар хүлээн зөвшөөрөгдсөн байна. Энэхүү арга хэмжээ нь тухайн бүсийн экосистемийн тэнцвэрт байдалд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

***Тэрбум мод ажлын хүрээнд***

